

ADB

Зүүн Азийн Газар 2011

Мэдлэгийн Удирдлагийн Санаачилга

Asian Development Bank



Зүүн Азийн Газар 2011

Мэдлэгийн Удирдлагийн Санаачилга

Asian Development Bank


© 2012 Азийн Хөгжлийн Банк

Зохиогчийн эрх баталгаажсан. 2012 оны хэвлэл.
Филиппин.

Хэвлэлийн дугаар. ARM125270

6 АХБ–ны гудамж, Мандалаяонг Сити
1550 Метро Манила, Филиппин
Утас +63 2 632 4444
Факс +63 2 636 2444
www.adb.org

Захиалгаа дараах хаягаар ирүүлнэ үү:
Гадаад харилцааны хэлтэс
Fax +63 2 636 2648
adbpub@adb.org

 Дахин боловсруулсан цаасан дээр хэвлэв

Агуулга

Гарчиг	Хэлтэс, албад	Хуудасны дугаар
Бодлогийн зөвлөмжийн цуврал		
1 ХАУ-ын Байгалийн нөөцийн татварын байдал (Ажиглалт, санал)	PRCM/EAOD	1
2 12 дугаар Таван жилийн төлөвлөгөө: Ерөнхий тойм, бодлогын зөвлөмж (Ажиглалт, санал)	PRCM	2
3 Орлогын дундаж түвшингээс шилжихэд Хятад Ард улсад тулгамдаж буй асуудлууд (Ажиглалт, санал)	PRCM	3
4 Муж, бүс нутгийн хөгжлийн стратегийн чиглэлээр АХБ –наас үзүүлсэн техникийн туслалцааны нөлөөлөл (Ажиглалт, санал)	PRCM	4
5 Хурдацтай хөгжиж буй эдийн засгийн удаашралт: Дэлхийн улс орнуудын жишээ болон Хятад Ард улс авах сургамж (Ажиглалт, санал)	PRCM/ERD	5
6 Хятад Ард улсын цахилгаан эрчим хүчний салбарын тулгамдсан асуудлууд болон ирээдүйн бодлогын чиглэлүүд (Ажиглалт, санал)	EAEN	6
7 12 дугаар таван жилийн хугацааны байгаль орчны стратегийн Хятад Ард улс 11 дүгээр таван жилийн төлөвлөгөөнөөс ямар сургамж авав? (АХБ Танилцуулга № 8)	EAER	7
8 Монгол улсад эрүүл мэндийн даатгалын удирдлага, зохицуулалтыг сайжруулах чиглэлээр хийгдэж буй ажлууд (АХБ Танилцуулга № 4)	MNRM	8
Тусгай нийтлэл		
9 Шийдэл олох цаг иржээ	PRCM	9
10 Амьдралыг тэтгэгч эх булгаа бид хэрхэн хамгаалж чадах вэ?	EAER	10
11 Эрчим хүчний хэмнэлтийн үнэлгээний системийн дизайн, хэрэглээ	PSOD/EAEN	11
12 Сонгхуа голын тухай баримтат кино	EASS	12
13 Хятад ард улсын үр тарианы үйлдвэрлэлийн гарцад уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлж буй нөлөөлөл — Бүсийн болон ургацын төлөв (АХБ-ны эдийн засгийн асуудлаархи ажлын баримт бичгийн цуврал №. 243)	EAER	14

14	Хятад Ард Улс дахь цаг уурын өөрчлөлт ба Бүс хоорондын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний арилжааны урсгал (АХБ-ны эдийн засгийн асуудлаархи ажлын баримт бичгийн цуврал №. 244)	EAER	15
15	Хөгжил дэвшлийн төлөөх түншлэл: Хятад оронд өгөөжөө өгсөн туслалцаа	EAOD	15
16	АХБ болон Монгол улсын Түншлэл: Маргаашийн сайн сайханы төлөө	EAOD	16
17	Хятад Ард улс, Азийн хөгжлийн банкны мэдлэг солилцох хамтарсан хөтөлбөр: Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааг дэмжихүй	EAOD	17
18	Зүүн хойд Ази дахь уур амьсгалын нөлөөний эдийн засгийн асуудлууд	EAOD	18
19	Хөдөөгийн дэд бүтцээр дамжуулан эмэгтэйчүүдийн чадамжийг дээшлүүлэх нь: Тээврийн салбарт жэндэрийн тэгш байдлыг хангахуй	EATC	19
20	Хятад улсад өнгөн хөрсөнд ойр газрын гүний гео энергийг ашиглалтыг нэмэгдүүлэх тухай	PSOD/EAEN	20
Салбар болон Сэдэвчилсэн судалгааны цуврал			
21	Аж үйлдвэрийн шилжилтийг дэмжих ерөнхий ухамсар, сэтгэлгээ болон бодлогын байдал ямар байгаад хийсэн судалгаа	EAOD	21
22	Их дээд сургууль, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны сайн жишээ	MNRM	22
23	Хятад ард улсын зээлийн хоёр дахь зах зээл	EAPF	23
24	2011–2015 онд Хятад Ард Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэл ба стратегид зориулсан тус улсын санхүүгийн салбарын үнэлгээ	EAPF	23
25	Хятад ард улсын хувийн хэвшлийн салбарын үнэлгээ	EAPF	24
26	Хятад ард улсын эрсдлийн үнэлгээ	EAPF	25
27	Хятад ард улс усны бохирдлын хяналтад зах зээлийн арга хэрэгслийг ашиглаж буй нь	EASS	26
28	Хятад ард улсын хот байгуулалтын тогтвортой хөгжил: Эко хотын хөгжил нь цааш хөтлөх шинэ, тогтвортой арга зам уу?	EASS	27
29	Лаг хаягдлын талаар Хятад ард улсаас баримталж буй стратеги: Тогтвортой шийдлийг дэмжихүй	EASS	28
30	Замын байнгын засварын ажлыг орон нутгийн иргэдэд түшиглэн хийж эмэгтэйчүүдийг оролцуулах—Зам засварын бүлгүүдэд зориулсан гарын авлага	EATC	29
31	Замын байнгын засварын ажлыг орон нутгийн иргэдэд түшиглэн хийж эмэгтэйчүүдийг оролцуулах—Мэдээллийн төвүүдэд зориулсан танилцуулга	EATC	29

32	Монгол улс: Замын салбарын хөгжил 2016 онд	EATC	30
33	Хятад ард улсад хэрэгжиж буй усны хагалбарын эко нөхөн төлбөрийн тухай	EAER	31
34	Хятад ард улсын тогтвортой хөгжлийн байгаль орчны асуудал: Ирээдүйн талаарх төсөөлөл ба Азийн хөгжлийн банкны гүйцэтгэх үүрэг	EAER	32
35	Монгол улсын тэтгэврийн даатгал	EAOD	33
Сайн туршлага солилцох тухай цувралууд			
36	Техник мэргэжлийн боловсрол, сургалтын сайн туршлага	EASS	35
37	Удирдамж тэмдэглэл: АХБ–ны усны төслүүдэд усны аюулгүй байдлын төлөвлөгөөг оруулах нь	PRCM	35
Техникийн асуудлаархи цуврал тэмдэглэл			
38	Хөгжиж буй эдийн засагтай орнуудад нүүрс хүчлийн хийн хаягдлыг олдворлох, нөөцлөх үйл ажиллагааг санхүүжүүлэх тухай	EAEN	38
39	Хятад улс дахь цахилгаан станцуудын тэнцвэрт бус өгөгдөл бүхий Malmquist–н нийт хүчин зүйлийн бүтээмжийн индекст ашиглагдаагүй үлдсэн хаягдлыг оруулах нь	EAEN	39

Зүүн Азийн Газрын Хэлтэс /Ажлын албууд (EARD)

EAER = Байгаль орчин, Байгалийн нөөц болон Хөдөө аж ахуйн хэлтэс

EAEN = Эрчим хүчний хэлтэс

EAOD = Ерөнхий захирлын алба

EASS = Хот байгуулалт ба нийгмийн салбарын хэлтэс

EATC = Тээврийн хэлтэс

MNRM = Монгол улс дахь суурин төлөөлөгч

PCRM = Хятад ард улс дахь суурин төлөөлөгч

АХБ-ны Удирдах газрууд

ERD = Эдийн засаг, Судалгааны Газар

PSOD = Хувийн Хэвшлийн Салбарын Үйл Ажиллагааны Газар

Өмнөх үг

Хэвлэгдэж эхлээд 5 жил болж байгаа жил тутмын эмхэтгэлийн энэ удаагийн дугаарт Зүүн Азийн газраас (ЗАГ) 2011 онд бэлтгэсэн Стратегийн мэдлэгийн 39 бүтээгдэхүүн, үйлчилгээний (СМБҮ) тайлангийн хураангуй орсон бөгөөд энд өгсөн линкээр бүрэн тайланг сонгож үзэх боломжтой. Энэхүү эмхтгэл нь ЗАГ-аас Мэдлэгийн удирдлагийн чиглэлээр хийсэн томоохон ажлын үр дүнгийн тайлан юм.

ЗАГ нь Хятад Ард улс (ХАУ) болон Монгол улсад явуулж буй зээл олголт, техник туслалцаа болон бодлогын чиглэлээр үзүүлж буй дэмжлэг туслалцааны үйл ажиллагаагаар дамжуулан мэдлэг бий болгоход онцгой анхаарал тавьж ирсэн бөгөөд мэдлэгийн удирдлага нь эдгээр үйл ажиллагааны салшгүй хэсэг юм. Энд танилцуулж буй СМБҮ нь ХАУ болон Монгол улсын эрэлт хэрэгцээнд тулгуурлан бий болсон билээ. Макро эдийн засгийн удирдлага, эрчим хүчний үр ашигтай зарцуулалт, байгаль орчныг хамгаалах, ядуурлыг бууруулах болон муж, аймгуудын хамтын ажиллагаа нь Хятад улсын чамгийн чухал сэдэв болж байна. ХАУ–д үйлдвэрлэлийн шилжилтийн бодлогуудыг (эрэг орчмын бүс нутгаас эх газрын бүсрүү, гадаад зах зээлээс дотоод зах зээлд) дэмжих, зээлийн хоёр дахь зах зээлийг хөгжүүлэх үндсэн СМБҮ-г бий болгов. Бодлогын асуудлаархи товч тэмдэглэлийн цуврал, Ажиглалт, Саналд 12 дугаар 5 жилийн төлөвлөгөө (ТЖТ), дундаж орлоготой орны шилжилт, байгалийн нөөцийн татварын асуудал, цахилгаан үйлдвэрлэлийн салбарын хүндрэл, тулгамдсан асуудлууд, орон нутгийн хөгжлийн стратегийн асуудлыг хамруулан авч үзэв. ХАУ-ын 12 дугаар ТЖТ–нд тусгасан байгаль орчны бодлогын талаар бодлогын товч танилцуулгыг бэлтгэн оруулав.

Монгол улсын хувьд гол СМБҮ нь эдийн засгийн өсөлт, тэр дундаа бүтээмжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдал багтаж байдаг ядуурлыг бууруулах юм. Их дээд сургууль – аж үйлдвэрийн хамтын ажиллагаа, мал аж ахуйн түүхий эдэд суурилсан үйлдвэрлэлийн сайн жишээ СМБҮ болж байна. Өөр нэг СМБҮ бол Монгол улсын тэтгэврийн даатгал, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын системийн засаглалын асуудлаархи бодлогын танилцуулга юм. Судалгааны зөвлөх баг 2008 оноос хойш Монгол улсын Засгийн Газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжил, Шинэтгэлийн хороонд (ҮХШХ) бодлогын чиглэлээр дэмжлэг үзүүлж ирсэн. ҮХШХ-ны ажилтнуудын судалгааны арга зүй, эдийн засгийн бодлогын ажлын чадавхийг дээшлүүлэхэд тустай бодлогын судалгааг тус зөвлөх баг хийв.

Олон улсын 7, үндэсний хэмжээний 29 уулзалт ярилцлага, 2 номын нээлтийг зохион байгуулан ХАУ болон Монгол улсын СМБҮ–г нийтэд хүргээд байна. АХБ болон ХАУ–н түншлэлийн 25 жилийн ой, АХБ болон Монгол улсын түншлэлийн 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны үеэр дундаж орлогын түвшин рүү шилжих, тогтвортой хөгжлийн тухай мэдлэгээ хуваалцах арга хэмжээг зохион байгууллаа. АХБ болон ХАУ–н түншлэлийн ойн Форумын үеэр *Хөгжил дэвшлийн төлөөх Түншлэл: Хятад оронд өгөөжөө өгсөн туслалцаа* илтгэл тавигдсан бол АХБ болон Монгол улсын түншлэлийн ойн ёслолын үеэр АХБ–ны Ерөнхийлөгч болон Монгол улсын Сангийн сайд хамтран *АХБ болон Монгол улсын Түншлэл: Маргаашийн сайн сайханы төлөө* эмхэтгэлийн нээлтийг хийсэн билээ. Энэхүү хоёр бүтээлийн аль аль нь АХБ–наас үзүүлсэн туслалцааны үр нөлөөний талаар өгүүлсэн байв.

Өмнөх үг

ХАУ-АХБ-ны мэдлэг солилцооны хөтөлбөрийг (МСХ) үргэлжлүүлэн, Хөдөө аж ахуй, Хөдөөгийн хөгжлийн талаархи мэдлэг солилцооны гурав дахь ярилцлага уулзалтыг 2011 оны 11 сарын 7–10-ны өдрүүдэд Бээжин хотод зохион байгуулж, АХБ-ны гишүүн хөгжиж буй 13 орон оролцов. Солонгос улсын Пусан хотод зохион байгуулсан Тусламжийн үр ашгийн талаархи дээд хэмжээний 4 дэхь Форум дээр ХАУ болон АХБ-ны мэдлэг солилцооны хөтөлбөрийг Өмнөд-өмнөд хамтын ажиллагааны инновацийн жишээ судлагдахуун болсон гэж онцолсон юм. 2011 оны 12 сарын 6–нд Өмнөд Африкийн Дурбан хотод болсон Талуудын 17 дугаар Бага Хуралдаанд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын конвенцийн үндсэн чиглэлд зориулан энэ хөтөлбөрийг АХБ танилцуулсан.

Мэдлэгийн удирдлага нь Зүүн Азийн Газрын БНХАУ болон Монголд үзүүлж буй тусламжийн стратегийн тэргүүлэх чиглэл хэвээр үлдэх бөгөөд мэдлэгийг нэмэгдүүлэх болон санаачлагатайгаар мэдлэгийг түгээхэд түлхүү анхаарах болно.



Роберт Уитхолл
Ерөнхий захирал
Зүүн Азийн Газар

Бодлогийн зөвлөмжийн цуврал



ХАУ-ын Байгалийн нөөцийн татварын байдал (Ажиглалт, санал)

www.adb.org/publications/natural-resource-taxation-prc?ref=countries/prc/publications

Хятад ард улс (ХАУ) 2010 оны 6 сард нефть болон байгалийн хийд ноогдуулах байгалийн нөөцийн нэмэгдсэн өртгийн 5% шинэ албан татварыг нэвтрүүлсэн бөгөөд одоо энэ татварыг Шинжаан Уйгарын Автономит мужид (Шинжаан) туршиж байна. Шинжаан муж тус улсын түүхий нефтийн 13%, байгалийн хийн бүтээгдэхүүний бараг 30% хувийг эзэлдэг. Энэ туршилт амжилттай хэрэгживэл бусад бүх муж, бүсүүдэд хэрэгжүүлнэ гэдгээ Засгийн газар зарлаад байна.

Байгалийн нөөцийн нэмэгдсэн өртгийн татварыг туршиж байгаа энэ туршлага нь олборлолтын тоо хэмжээнд суурилсан татвараас байгалийн гаралтай түүхий эдийн үнийн өөрчлөлтөд илүү зохицсон, хэлбэлзлээс ангид байх татвар луу шилжих чиглэл рүү хийхэд тустай арга замын нэг юм. Энэхүү нэмэгдсэн өртгийн татвараар дамжуулан хөрөнгө оруулагчдад татварын тогтвортой байдлыг бий болгож өгдөг. Гэхдээ анхаарал болгоомжтой хэрэгжүүлэхгүй бол хэрэгжүүлэх явцад олборлолтоос олох орлогоос доогуур хэмжээнд хүргэж болзошгүй тул адармаатай, сорилт бүхий арга зам юм.

Нягт судлагаа, анхаарал шаардсан дараах хэд хэдэн үндэслэлийг энэхүү Бодлогын тухай тэмдэглэлд авч үзсэн байна. Үүнд: (i) шилжилтийн үнэ тогтоолтын эрсдэлийг багасгах үүднээс хуваарилалтыг хянах, (ii) Байгалийн нөөцийн ашиглалтын нэмэгдсэн өртгийн татварт зориулан борлуулалтыг тооцсон индексжүүлэлт механизмийг тогтоох (iii) байгалийн нөөцийн НӨАТ-ийг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх, (iv) байгалийн нөөцийн ашиглалтын татварын зохистой хэмжээг тодорхойлох, (v) инфляцийн эрсдлийг харгалзах (vi) орон нутгийн засаг захиргааны орлогын хувь хэмжээг нэмэгдүүлэх

Шинжаан мужид хэрэгжүүлэн туршиж үзсэн байгалийн нөөцийн НӨАТ нь нефть болон хийн олдворлолтын төслүүдээс орон нутагт ноогдох орлогын хэмжээг нэмэгдүүлэх таатай боломжийн талаарх санааг дэвшүүлсэн байна. Тиймээс үүнийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхийг санал болгож байгаа юм.

Байгалийн нөөцийн суурь бүхий татварын шинжилгээг түүхий нефть болон байгалийн хийтэй холбоотой татваруудыг

оруулан хамтад нь авч үзэх, тэр дундаа эрдсийн салбар асар их интегралчлагдсан, олдворлолт, боловсруулалт, эцсийн бүтээгдхүүний борлуулалтыг ихэнхдээ ганц компани хариуцдаг Хятад ард улсад шинжилгээг ийм аргаар хийх хэрэгтэй.

Байгалийн нөөцийн ашиглалтын нэмүү өртгийн албан татварын борлуулалтыг тооцсон индексжүүлсэн татварыг тогтоох хэрэгтэйг санал болгож байна.

Түүхий нефть болон хийг байгалиас олборлож, олон улсын зах зээлд худалдаалдаг тул эдгээр бүтээгдхүүнийг бусад нөөцүүдэд хамруулан үзэж болох үндэслэл байна.

Бусад орнуудтай харьцуулахад Шинжаанд нэвтрүүлсэн байгалийн нөөцийн 5 хувийн татвар нь доогуур түвшинд орж байна. Бусад орнуудын түүхий нефть болон байгалийн хийд ноогдуулах татварын стандартыг шинжлэн үзэж байгалийн нөөцийн татварыг ямар хэмжээгээр нэмэгдүүлж болохыг тодорхойлох нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.



12 дугаар Таван жилийн төлөвлөгөө: Ерөнхий тойм, бодлогын зөвлөмж (Ажиглалт, санал)

www.adb.org/publications/12th-five-year-plan-overview-and-policy-recommendations?ref=countries/prc/publications

Хятад Ард улсын 12 дугаар таван жилийн төлөвлөгөөний гол зорилтуудад эдийн засгийн өсөлтийг үйлчилгээ, хэрэглээг илүү баримжаалсан загварлуу шилжүүлэн өөрчилж, Хятад ард улсын нийгэм, байгаль орчин, гадаад тал дахь тэнцвэрийг хангахад өмнөх үеийн аж үйлдвэржилт, үйлдвэрлэл, капитал, хөрөнгө орлуулалт, экспортыг гол болгосон чиглэл, хандлагаас татгалзах зайлшгүй шаардлага гарч байна. Таван жилийн төлөвлөгөөний үндсэн зорилтоос харахад эдийн засагт шинэ тэнцвэрийг бий болгох өмнөх төлөвлөгөөг үргэжлүүлэх нь тодорхой харагдаж байгаа хэдий ч шинэ санаачилгад суурилсан үйлдвэржилтийн бодлого, нүүрс хүчлийн хийн хаягдал багатай эдийн засагруу илүү чиглэсэн шийдвэртэй алхмууд нь өмнөх төлөвлөгөөнөөс ялгаатай, шинэ зүйл юм.

Бодлогод зоригтой өөрчлөлт хийхгүйгээр шинэ тэнцвэрийг бий болгох аргагүй. Бодлогын чиглэлээр анхаарах ёстой зарим нэг гол чиглэлүүдэд (i) хөрөнгө оруулалтыг төсөвт илүүтэй зарцуулдаг байдлыг нийтийн үйлчилгээрүү түлхүү хандуулан шилжүүлэх, (ii) санхүүгийн секторын либералчлалыг гүнзгийрүүлэх, (iii) эдийн засагт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, (iv) орлогын тэгш биш байдлыг бууруулах, орон нутгийн засаг захиргааны санхүүг бэхжүүлэх үүднээс хийх шаардлагатай байгаа төсвийн шинэчлэл орж байна.



Орлогын дундаж түвшингээс шилжихэд Хятад Ард улсад тулгамдаж буй асуудлууд (Ажиглалт, санал)

www.adb.org/publications/challenges-middle-income-transition-prc?ref=countries/prc/publications

Олон улсын туршлагаас үзэхэд дундаж орлогын түвшингээс орлогын өндөр түвшинрүү дэвшиж орох нь бага орлоготой байдлаас дундаж орлогын түвшин лүү шилжиж орохоос илүү төвөгтэй байдгийг харуулж байна. Түүнээс гадна, хөгжлийн эхний шатуудад баттай амжилтанд хүргэсэн хөгжлийн стратегиуд орлогын түвшин ахих тутам үр дүн багатай болдог.

30 жилийн турш амжилттай хийгдэж ирсэн шинэчлэлийн үр дүнд Хятад улс дэлхийн хоёр дахь том эдийн засагтай орон болсон. Энэхүү хурдацтай өсөлтийн үр дүнд тус улс бага орлоготойгоос дундаж орлоготой улс болох огцом үсрэлт хийсэн бол өндөр орлоготой түвшинд хэрхэн дэвшиж орох нь өнөөдөр сорилт болж байна.

Хятад ард улс өсөлтийг урт хугацааны турш тогтвортой байлгах стратегийг боловсруулахад олон улсын туршлагаас авсан зарим нэг сургамжууд хэрэгтэй болж болох юм. Үүнтэй уялдан 12 дугаар таван жилийн төлөвлөгөөнд нэн шаардлагатай байгаа шинэтгэлийг тусгаж, эдийн засгийн шинэ тэнцвэрийг бий болгох ерөнхий агуулгад багтаан оруулжээ.

Иймээс энэхүү төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх нь Хятад ард улсыг өндөр орлоготой орны түвшинд дэвшүүлэх гол хүчин зүйл байх юм.

Бодлогын чанартай зөвлөмжүүдэд:

- Дараах хүчин зүйлүүдээр хэрэглээг өсөлтийн эх үүсвэр болгох арга зам нь:
 - нийгмийн зориулалттай зарцуулалтыг нэмэгдүүлэх, боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэрт зарцуулах төсвийн зарцуулалтыг нэн тэргүүнд тавих; болон
 - хэрэглээний санхүүжилтийг өргөжүүлэх замаар
- өсөлт, үйлчилгээний хөгжлийг тэтгэх эх булаг болсон эх үүсвэр, нөөцийг төрөлжүүлэх, хотжилтыг дэмжих арга зам нь:
 - үйлчилгээг хөгжүүлэх;
 - хөрөнгийн хувиарлалтыг сайжруулах; болон
 - хотжилтыг дэмжих замаар бий болгох
- шинэчлэлд суурилсан өсөлтийг дэмжих арга зам нь:
 - судлагаа, шинжилгээ, хөгжүүлэлтэд зориулах эх үүсвэрийг нэмэгдүүлэх; болон
 - шинэчлэлийг дэмжих үүднээс боловсролын шинэтгэлийг хийх
- тэгш бус байдлыг бууруулах арга зам нь:
 - орлогын хувиарлалтыг бэхжүүлэх; болон
 - төсвийн санхүүжилтийг бэхжүүлэх



Муж, бүс нутгийн хөгжлийн стратегийн чиглэлээр АХБ–наас үзүүлсэн техникийн туслалцааны нөлөөлөл (Ажиглалт, санал)

Энэхүү тэмдэглэлд АХБ –наас Хятад ард улсын Чуньчинь, Гансу, Гуанжу, Жөжан, Хүнвань, Өвөр Монгол, Жаньши, Жилин, Шинжаан Уйгарын автомат муж зэрэг хэд хэдэн муж, аймгууд, өөртөө засах эрх бүхий мужуудад хийсэн судалгаагаар дамжуулан орон нутгийн хөгжлийн стратегийг боловсруулахад Хятад Ард улсад (ХАУ) сүүлийн жилүүдэд үзүүлсэн техник туслалцааны нөлөөллийг онцлон авч үзсэн болно.

Бүс, муж, орон нутгийн хөгжлийн стратегийг сайн боловсруулах нь орон нутгийн хөгжилд амжилттай дэмжлэг болдог гэдгийг судалгаагаар харуулсан. Азийн хөгжлийн банкнаас боловсруулсан орон нутгийн хөгжлийн стратеги, Засгийн газрын хөгжлийн стратеги түүнчлэн Азийн хөгжлийн банкнаас Хятад улсад хэрэгжүүлж буй стратегиуд хоорондоо ихээхэн уялдан тохирч байна.

Азийн хөгжлийн банкнаас санал болгосон зөвлөмжүүдийг Засгийн газар, орон нутгийн засаг захиргаанаас боловсруулсан эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөлтийн чухал бүрэлдэхүүн хэсэг болгон авч хэрэглэжээ.

Бүс нутгийн хөгжлийн стратегийн чиглэлээр хийгдсэн эдгээр судалгаа нь муж, бүс нутаг бүрийн хамгийн чухал амин асуудалыг дэвшүүлэн гаргаж ирсэнээрээ онцлогтой юм.

Хэбэй мужийн хөгжлийн стратеги нь тус мужийг Бээжин болон Тяньжиний эдийн засагтай хамгийн зөв, үр дүнтэй арга замаар хэрхэн нэгтгэхэд голлон анхаарсан юм. Бээжин, Тяньжин хотуудтай бүс нутгийн эдийн засгийн хамтын нөхөрлөл байгуулан, уялдан холбогдсон хамтын зорилгын төлөө аль алиныхаа давуу талтай зүйлээр хоршин ажиллах боломжийг бүрдүүлэхийн төлөө улам илүү чармайлт гарган ажиллах шаардлага Хэбэй мужид тавигдаж байна.

Хэбэй мужийн хөгжлийн стратегид “Бээжин, Тяньжин орчмын ядуурлын бүс” гэсэн шинэлэг үзэл баримтлалыг томъёолон гаргаж ирсэнээр Бээжин, Тяньжин орчмын бүсэд амьдарч буй Хэбэй ядууралд өртсөн хүн амын асуудлыг хэрхэн шийдэх болон экологийн аюулгүй байдлыг хэрхэн удирдах хэд хэдэн арга хэмжээг санал болгосон.


Өвөр Монголын өөртөө засах орны хөгжлийн стратегийн судалгаа нь энэ бүс нутгийг тус улсын эрчим хүчний бааз суурь болгон хөгжүүлэх чармайлтыг эрчимжүүлэхэд чиглэж байна. Харин Шинжаан Уйгурын мужийн хувьд хөгжлийн стратеги нь тус мужийн харьцангуй давуу тал болсон Төв Азитай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхийг гол болгосон. Шинжаан Уйгурын өөртөө засах муж өрнөдөд нээлттэй болох, Төв Азийн орнуудтай хөгжүүлэх хамтын ажиллагааг хойд бүс нутагтаа Оросын Холбооны улс, улмаар Афганистан, Энэтхэг, Иран, өмнөд бүс нутагтаа Пакистан улсыг хамруулсан Пан Азийн бүсийн хамтын ажиллагаа болгон өргөжүүлэх санаа судалгаанаас дэвшигдэн гарч байна.

Бүсийн хөгжлийн стратеги нь хөгжлийн шинэ үзэл баримтлалыг дэвшүүлсэн. Энэ үзэл баримтлал нь нь хил дамнасан эдийн

засгийн хамтын ажиллагааны бүсийг Ордост байгуулан, түүнчлэн Шинжаан уйгурын мужийн өмнөд болон хойд нутгийн аль алинийх нь эдийн засгийн хөгжлийг дэмжихийн тулд Тэньшин уулын хойд бэлд эдийн засгийн өсөлтийн “Алтан гурвалжинг” бий болгох санааг дэвшүүлж байгаа юм.

Хунаны хөгжлийн стратегийн судалгаа нь нь тухайн мужийн нөхцөл байдал, шинэ санаачилга, нүүрсхүчлийн хийн хаягдал багатай ногоон өсөлт, аж үйлдвэрийн төвлөрөл болон газрын хэмнэлтийг дэмжих санаачлагуудыг багтаасан “гурван дэмжлэг, нэг байгуулалт” стратегийг боловсруулахыг авч үзсэн. Судалгааны зөвлөмж нь Чанша–Жужоу–Шиантан бүсийн өсөлтөд нөлөөлж, нөөцийн хэмнэлт, байгаль орчинд стратегийн ээлтэй дэмжлэг үзүүлж байна.

Жаньшийн хөгжлийн стратеги нь хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжлийн урт хугацааны төлөвлөгөөг томъёолон, 2020 гэхэд малчид фермерүүдийн цэвэр орлогыг 10,000 юаньд хүргэхэд чиглэсэн арга замуудыг санал болгон хөдөө аж ахуй, малчид, фермерүүд, хөдөөгийн хөгжлийн асуудлыг голчлон авч үзсэн. Судалгаа хөдөө аж ахуйн үр ашгийг шинэ шатанд гаргах үүднээс хүнсний аж үйлдвэр болон хөдөө аж ахуйтай холбоотой бусад аж үйлдвэрийн хөгжлийг түргэтгэн ургашлуулах тодорхой зөвлөмжийг өгсөн байна.



Хурдацтай хөгжиж буй эдийн засгийн удаашралт: Дэлхийн улс орнуудын жишээ болон Хятад Ард улс авах сургамж (Ажиглалт, санал)

www.adb.org/publications/slowdown-fast-growing-economies-international-evidence-and-implications-prc?ref=countries/prc/publications

Дэлхийн улс орнуудын түүхэн туршлагаас харахад хурдацтай өсөлттэй байгаа хөгжиж буй орнуудад орлогын түвшин нэмэгдэх тутам өсөлт цаашдаа удааширдагийг харуулж байна. Энэ сургамжийг үндэс болгон хийсэн судалгаанаас Хятад Ард улсын (ХАУ) нэг хүнд ноогдох орлого өсөлт удаахрах тэр түвшинд хүрч байна гэсэн санааг дэвшүүлж байна. Хятад улс урьд гарч байгаагүй өсөлт гаргаж, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш нь асар өндөр өрсөлдөх чадвартай байдлыг хадгалж, дотоодын нийт бүтээгдэхүүний багахан хувь хэрэглээг хангаж байгаа бөгөөд одоо хүн амын насжилт эрчимтэй явагдаж байгаа нь өсөлт удааширч болзошгүй гэдгийг харуулж байна.

Өсөлт нь механик үзэгдэл биш болохоор энэхүү нөлөөллийг зогсоох бодлогын хувилбарууд байна. Энэ байдлаас харвал үндэсний валютын ханш буурах, хэрэглээ буурах болон хүн амын огцом насжилт гэсэн хамгийн өндөр эрсдэл бүхий гурван хүчин зүйлийг тусгасан шинэчлэлд голлон төвлөрч ажилласанаар ХАУ–н огцом өсөлтийн хугацааг уртасгах хэд хэдэн зөвлөмжийг санал болгожээ.



Хятад Ард улсын Цахилгаан эрчим хүчний салбарын тулгамдсан асуудлууд болон ирээдүйн бодлогын чиглэлүүд (Ажиглалт, санал)

<http://beta.adb.org/publications/peoples-republic-china-electricity-sector-challenges-and-future-policy-directions?ref=countries/prc/publications>

1949 онд Хятад Ард улсын (ХАУ) цахилгаан эрчим хүчний салбарын суурилсан хүчин чадал 2 гигаваттаар (ГВТ) тооцоогдож байсан бол 2010 он гэхэд 900 гаруй ГВТ-н хүчин чадалтай болтлоо хөгжлийн урт замыг туулсан юм. Эхэн үедээ хоцрогдонгуй, удаан байсан энэ салбарт ялангуяа сүүлийн 20 жилийн туршид хурдацтай өсөлт гарсан. 2001–2010 хугацаанд энэ салбарын хүчин чадал гурав дахин нэмэгджээ. Хэдийгээр өсөлт байгаа ч цахилгаан эрчим хүчний эрэлтийн хэлбэлзэлтэй үед энэ салбарт доголдол гарч байна.

Өвөл, зуны эрчим хүчний эрэлт хэрэгцээний оргил үе, нүүрс тээвэрлэлтэд гарч байгаа саатал, хүндрэлтэй хавсран улирлын чанартай хомсдол олонтаа гарахад хүргэж, эрэлт нийлүүлэлтийн тогтворгүй байдалд дарамт үүсгэж байна. Хүчин чадлаас доогуур ашигласан эсвэл хүчин чадлаас давах үзэгдэл 2003–2004 болон 2010–2011 давтагдсан нь нийт эдийн засагт мөн нөлөөгөө үзүүлж байна.

ХАУ-ын цахилгаан эрчим хүчний салбар ийм нүсэр дэд бүтцийг төлөвлөх, ажиллуулах болон удирдахад шаардагдах технологийн дэвшил болон хөгжилтэй ерөнхийдөө хөл нийлж ирсэн. Дарамт, бэрхшээл ямар нэг хэмжээгээр байгаа ч хамрах хүрээ, нүсэр бүтэц бүхий бусад орны ижил төстэй сүлжээнд гардаг гамшгийн дайтай уналт доголдол гаргахгүй нилээд сайн ажиллаж ирсэн.

Өмнө хийсэн болоод одоо хийгдэж байгаа шинэчлэлийн үр дүнд энэ салбар ихээхэн ололт амжилтанд хүрээд байгаа хэдий ч нөөцийн тохиромжтой сонголт хийх, байгаль орчны хязгаарлалт, уур амьсгалын өөрчлөлт болон нүүрс хүчлийн ялгарлыг бууруулах санаачлага гэх зэрэг шинэ шинэ асуудал, сорилттой тулгарч байна. Эдгээр асуудлууд нь өөрчлөлтийн гол хөтлөгч болж байгаа буюу цаашид болох бөгөөд шинэтгэл, шинэ санаачлагийг гүнзгийрүүлэхийг шаардаж байна.

Бодлогын энэхүү тэмдэглэлд эдгээр шинэ шинэ асуудал, сорилтыг шийдэх чиглэлээр ажиллахын сацуу урт хугацаанд тогтвортой байдлыг бий болгоход нийцтэй бодлогын зөвлөмж өгөх үүднээс эрчим хүчний салбарын гол гол сорилтууд, бэрхшээлүүдийг нарийн судалж үзсэн байна. Бодлогын зөвлөмжид:

- цахилгаан үйлдвэрлэлийн урамшуулалт тариф,
- зохицуулалт болон ачааллаас хамаарсан уян хатан тариф,
- олон нийтэд хандсан сурталчилгаа таниулга, боловсролын хөтөлбөр,
- бүтцийн өөрчлөлт, зохицуулалт,
- салбарын төлөвлөлт, ерөнхий хяналтыг дээшлүүлэх,

- хүчин чадлыг нэмэхээс илүүтэй хэмнэлтэд чиглэсэн хандлагыг дэлгэрүүлэх,
- салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах,
- үндсэн оролцогч талуудаас салбарын алс хэтийн төлвийг тодорхойлох,
- цахилгааны бөөний болон жижиглэнгийн зах зээлийг бий болгох , болон
- шинэ санаачлага, судлагааг шинжилгээ, хөгжүүлэлтийг аж ахуйн нэгж болон Засгийн газрын түвшинд дэмжихийг оруулжээ.



12 дугаар таван жилийн хугацааны байгаль орчны стратеги: Хятад Ард улс 11 дүгээр таван жилийн төлөвлөгөөнөөс ямар сургамж авав? (АХБ Танилцуулга № 8)

www.adb.org/publications/environmental-strategy-12th-five-year-plan-period-what-can-peoples-republic-china-learn

Хятад Ард Улс 11 дүгээр таван жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн жилүүдэд (2006–2010) өмнөх 5 жилтэй харьцуулахад байгаль орчны чиглэлээр онцгой амжилтанд хүрч, хүхрийн давхар исэл, химийн аргаар гаргасан хүчилтөрөгчийн эрэлт, эрчим хүчний төвлөрөл, хэмжээг бууруулах зорилгод хүрлээ. 11 дүгээр таван жилийн төлөвлөгөөтэй харьцуулахад олсон амжилт хувь нэмрээ оруулсан гол хүчин зүйлүүдийн дотор хөрөнгө оруулалтын өсөлт, тодорхой чиглэлд илүүтэй төвлөрсөн байдал, хариуцлага тооцох болон хуулийн хэрэгжилтийг бэхжүүлсэн байдал орж байна.

Ийм амжилт олсон хэдий ч үйлчилгээнээс илүү үйлдвэрлэлд, хэрэглээнээс илүүтэй хөрөнгө оруулалтад тулгуурласан эдийн засгийн өсөлтийн хэв шинж нь тус улсын орчинд ихээхэн дарамт үзүүлж байна. Өсөлтийн өнөөгийн хэв шинжид суурь өөрчлөлт оруулах нь тус улсын хотжилтод хандаж байгаа “өсөлт рүү улайрах” хандлага, эрчим хүчний бүтцэд нүүрс давамгайлсан байдал, байгаль орчны удирдлага нь захиргааны арга хэмжээнээс хэт хамааралтай байдлаа хэр хурдан даван туулж чадахаас хамаарна.

Энэ сул талыг арилгахын тулд 12 дугаар таван жилийн төлөвлөгөөнд дараах арга хэмжээг авч үзэхийг АХБ–ны танилцуулгад зөвлөмжилсэн байна. Үүнд: (i) нөөцийн үнийг өөрчилж, саад тотгорыг арилгах, (ii) бохирдлыг хянахын тулд зах зээлийн арга хэрэгслийг нэмэгдүүлэх, болон (iii) хариуцлагыг тодорхой болгох, хамтын ажиллагааг өдөөх үүднээс хуулийн шинэтгэлийг хөгжүүлэх.



Монгол улсад олон нийтийн эрүүл мэндийн даатгалын удирдлага, зохицуулалтыг сайжруулах чиглэлээр хийгдэж буй ажлууд (АХБ Танилцуулга № 4)

Монгол улсад олон нийтийн эрүүл мэндийн даатгал (ОНЭМД) 1994 онд үүсэн бий болсон цагаас хойш ихээхэн зүйлийг хийж амжуулсан хэдий ч шинэтгэлийн явц 10 гаруй жил сунжирсан нь даатгуулагчид сэтгэл дундуур байхад нөлөөлж байна.

Бодлогын энэхүү танилцуулгыг Монголын ЭМД-н одоо өрнөж буй хэлэлцүүлэгт нэмэр болгохыг зорьжээ. Танилцуулга сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд шинэтгэлийг сааруулах саад тотгор болоод байгаа ЭМД-ын системийн засаглал, институцитай холбоотой асуудалд голлон анхаарчээ.

Засаглалын алаг цоог зохицуулалт, зохион байгуулалт, институцийн чадавхи дорой байгаа нь ЭМД-ын хяналт, хариуцлага эргэн тооцолтыг сулруулж, эрүүл мэндийн даатгалаар төлбөр хийж үйлчилгээ авч байгаа даатгуулагч сувилгаа, эмчилгээний чанарыг сайжруулахад нөлөөлөх байр суурьтай байдаг тийм хэрэгслэл болгон хөгжүүлэхэд саад болж байна.

Эрүүл мэндийн үйлчилгээг худалдан авагч байгаа даатгуулагчийн бие даасан байдлыг тогтоож, Эрүүл мэндийн даатгалын Зөвлөлд тайлагнадаг болгосоноор эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллага, даатгалаараа төлбөрөө төлж үйлчилгээ авч байгаа даатгуулагчийг зааглан тусгаарлаж, эрүүл мэндийн даатгалын эрүүл мэндийн үйлчилгээ худалдан авах чадварыг дээшлүүлэн, эрүүл мэндийн нийтийн даатгалыг эзэмшилдээ авах гэсэн яамд хоорондын зөрчлөөс сэргийлнэ.

Монгол улсад ЭМД-г бэхжүүлэхэд дараах зөвлөмж өгчээ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын бие даасан байгууллагыг байгуулах.
- Эрүүл мэндийн даатгалын төлбөр хийх чиг үүргийг бэхжүүлэхийн тулд эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагаас төлбөрийг даатгалаар хийдэг чиг үүргийг салган тусад нь гаргах.
- ЭМД-ын байгууллага хуулийн хүрээнд ажиллаж, үйл ажиллагаанд нь төрийн эрх бүхий байгууллагаас хяналт тавьдаг болгох.
- ЭМД-ын институтчлэлийн чадавхийг дорвитой бэхжүүлэх.

Тусгай нийтлэлүүд



Шийдэл олох цаг иржээ

www.chinadaily.com.cn/opinion/2011-03/04/content_12113413.htm

2011 оны 3 дугаар сарын 4-ний Чайна Дэйли сонинд гарсан энэ өгүүлэлд Хятад Ард улсын (ХАУ) хувьд эдийн засгийн өсөлтийн хэв шинж, хандлагад өөрчлөлт хийх хэрэгцээ 5 жилийн өмнөхөөс илүү их байгааг дурьджээ. Энэ нь нэг талаас гадаад тэнцвэрт бус байдал улам бүр тод болсон, нөгөө талаас экспортод хөтлөгдсөн загварын эрсдлийг тод томруунаар харуулсан дэлхий нийтийг хамарсан саяханы хямралаас үүдэлтэй.

Гэхдээ бодлогод зоригтой өөрчлөлт хийхгүйгээр шинэ тэнцвэрийг бий болгох магадлал бага. Бодлогын чиглэлээр анхаарах ёстой зарим нэг гол чиглэлүүдэд (i) хөрөнгө оруулалтыг төсөвт илүүтэй зарцуулдаг байдлыг нийтийн үйлчилгээ рүү түлхүү хандуулан шилжүүлэх, (ii) санхүүгийн секторын либералчлалыг гүнзгийрүүлэх, (iii) эдийн засагт хувийн секторын оролцоог нэмэгдүүлэх, (iv) орлогын тэгш биш байдлыг бууруулах, орон нутгийн засаг захиргааны санхүүг бэхжүүлэх үүднээс хийх шаардлагатай байгаа төсвийн шинэтгэл орж байна.

Өргөн хүрээнд хийгдэх олон талт шинэтгэлийг 12 дугаар таван жилийн хөгжлийн шинэ төлөвлөгөөнд ямар нэг хэмжээгээр тусгасан тул тэдгээрийн хэрхэн амжилттай хэрэгжүүлэх вэ гэдэг нь тулгамдсан асуудал болоод байна. Гадаад ертөнцөд үүд хаалгаа нээж, 30 жил шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлсэний үр дүнд ХАУ дэлхийн хоёр дахь том эдийн засагтай орон болж, тус улс бага орлоготой орноос орлогын дундаж түвшинд хүрсэн орон болох шилжилт хийсэн. Одоо энэ улс өндөр орлоготой түвшинд хэрхэн дэвших нь өнөөдөр сорилт болж байна. Үүнийг зорьж ажиллахад, урт хугацааны өсөлтийг хадгалах, дундаж орлогын занганаас зайлсхийхэд хүртээмжтэй өсөлт, байгаль орчны тогтвортой байдлын зүг тийш илүү эрс шийдэмгий алхам хийх шаардлагатай байна.



Амьдралыг тэтгэгч эх булгаа бид хэрхэн хамгаалж чадах вэ?

www.adb.org/news/op-ed/how-we-can-protect-elixir-life

2011 оны 11 дүгээр сарын 15-ны Чайна Дэйли сонинд гарсан энэ өгүүлэлд гүний усны хангамжийг хамгаалах, чанарыг тогтвортой барихад Хятад Ард улсад (ХАУ) учирч байгаа хүндрэл, тулгамдаж буй асуудлыг дурьджээ.

Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа тус улсын гүний гүний усны нөөцийг хамгаалахад асар их бэрхшээлтэй тулгарч байна. Асуудлын цар хүрээ далайц нь өргөн, ойлголт ерөнхийдөө дутмаг байгаагийн аль аль нь санаа зовоосон асуудал болж байна. Гүний усыг ихэнхдээ “нуугдмал” нөөц гэж нэрлэдэг бөгөөд олон хүн энэ “нуугдмал” нөөцийг бохирдуулах эрсдлийг өөрсдийн үйл ажиллагаатай шууд холбон үздэггүй. Гүний усны эх үүсвэрийн доройтлыг буцаахад хэцүү, хожуу шатанд цэвэршүүлэх нь бодит бус хувилбар юм. Гүний усыг үр дүнтэй хамгаалж, зөв менежментээр зохицуулах нь бүс, орон нутгийн түвшинд яригдах, шийдэгдэх асуудал байдаг.

ХАУ гүний усыг ихээр татаж, түүнийхээ ихээхэн хэсгийг нийт тариалангийн газрын 40 гаруй хувийг услахад ашигладаг. Нутгийн хойд хэсэгт амьдардаг хүмүүсийн 70% гүний усыг унданд хэрэглэдэг бөгөөд тус улс усны нөөцийн ихээхэн бохирдол, уур амьсгалын өсөн нэмэгдэж байгаа өөрчлөлтийн нөлөөнд нэрвэгдэж байна. Хот суурин болон аж үйлдвэрийн бүсэд хаягдал усыг цэвэрлэх, зайлуулах дэд бүтэц сул, химийн болон хүнд металлын бохирдуулагчийн нэвчилтийн улмаас гүний ус бохирдож байна. Бордоог хэтрүүлэн ашиглах мөн малын тоо толгой нэмэгдсэнээр аммиак, бактерлогийн бохирдол үүсэх гол шалтгаан болж буй бөгөөд хөдөө орон нутагт хүмүүс гадаргын усыг шууд хэрэглэх аргагүй болж байна.

АХБ-ны Хятад улсад хэрэгжүүлж буй түншлэлийн стратегийн хүрээнд гүний усны менежментийн бодлогыг сайжруулахад голлон анхаарч Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаанаас усны нөөцийн удирдлагыг сайжруулах талаар хийж байгаа ажилд АХБ туслалцаа үзүүлж байна. АХБ-ны түншлэлийн стратеги нь (i) гүний усны, зэрэгцээ гадаргын усны ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх; (ii) ус, түүний дотор гүний усны эдийн засгийн үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх; (iii) гүний усны чанар, ашиглалтын мониторингийг сайжруулах; (iv) гүний усны нөөцийг сэлбэх техникийн шийдэл олох; болон (v) нутгийн иргэд, оршин суугчдад гүний усыг хамгаалах, удирдах хариуцлагыг үүрүүлэн чадавхижуулахыг дэмжиж байна.

Иймээс мэдээлэл цуглуулах, удирдах, асуудлын хүрээ, эрэмбийг тодорхойлон тогтоох, хууль тогтоомжийг мөрдүүлэх чиглэлээр Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны ойлголт, чадавхийг нэмэгдүүлэх нэн шаардлагатай байна. Бордоог хэтрүүлэн ашиглах зэрэг нэвчилтээс үүдэлтэй бохирдлын асуудлыг шийдэхэд цэвэр техникийн эсвэл захиргааны шийдлүүд үр дүнгүй тул илүү их оролдлого, хүчин чармайлт шаардана. Хөдөө аж ахуйн хэрэглээний химийн бодисуудын хэрэглээг бууруулах, хөдөө аж

ахуй эрхлэлтийн ерөнхий практикийг сайжруулахын төлөө Засгийн газар, орон нутгийн засаг захиргаад малчид, малчдын холбоодтой хамтран ажиллах шаардлагатай. Энэ ажлыг хийхэд урт хугацааны оролцоог дэмжсэн бодлого хэрэгтэй.



Эрчим хүчний хэмнэлтийн үнэлгээний системийн дизайн, хэрэглээ

Хятад Ард улсын (ХАУ) дэлхийн хамгийн том эрчим хүч хэрэглэгч болоод байна. Тус улсын эдийн засаг нь нүүрсээс маш их хамааралтай. 2009 онд үйлдвэрлэсэн нийт цахилгаан эрчим хүчний 80 орчим хувийг нүүрсээр ажилладаг үйлдвэрүүд үйлдвэрлэсэн бол нүүрсхүчлийн давхар ислийн хаягдлын 50 орчим хувь нүүрс шатаасны улмаас үүссэн байв.

Эдийн засгийн ирээдүйн өсөлтийг тогтвортой байлгахын тулд ХАУ-д илүү найдвартай, бохирдол багатай эрчим хүчний нийлүүлэлт шаардлагатай байгаа нь тодорхой байна. Засгийн газар сүүлийн арван жилийн хугацаанд эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, CO₂-н бохирдлыг бууруулах чиглэлээр асар их хүчин чармайлт гарган ажилласан. Эрчим хүчний хэмнэлтийн талаархи бодлого, журам олныг боловсруулан гаргаж, эдийн засгийн бүх асуудлыг хамруулсан хөтөлбөрийг бий болгосон. Засгийн газраас хэрэгжүүлсэн 11 дүгээр таван жилийн төлөвлөгөөнд (ТЖТ) 2006–2010 онд дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) эрчим хүчний зарцуулалтыг 20% бууруулах хатуу зорилтыг дэвшүүлсэн.¹ ХАУ-ын эрчим хүчний салбарыг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахад онцгой анхаарч байгаа стратеги чиглэл бол эрчим хүчний хэмнэлт юм.

Тус улсын эрчим хүчийг хэмнэх асар их нөөц боломжийг ашиглахад ХАУ-д захиргааны болон зах зээлийн арга хэрэгслийн аль аль нь хэрэгтэй. Зах зээлд баримжаалсан эдийн засагт хувийн хэвшлийнхэн эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг бүрэн анхаарч ажиллахгүй байгаагаас үүдэлтэй байгаль орчин, эрчим хүчний аюулгүй байдлын дам нөлөөлөл их. Зах зээлийн хөдөлгөгч хүчнээс хамаарсан байдал, хөрөнгө оруулалтын төлвийг өөрчлөх, эзэмшигчдийн үр ашиггүй өмчийг багасгахад нилээдгүй хугацаа шаардагдаж болох бөгөөд эрчим хүчний хэмнэлтийн үр дүнд бий болсон ололтыг бүрэн дүүрэн ашиглахад хүндрэл учруулж болох юм. 11 дүгээр ТЖТ-ний хүрээнд авч хэрэгжүүлсэн орон нутгийн эрчим хүчний үр дүнгийн заавал хүрэх зорилт, эрчим хүчний хэмнэлтийн талаар төр-аж ахуйн нэгжийн хоорондын гэрээ, гүйцэтгэлийн доод шаардлагад хүрэх эрчим хүчний үр ашгийн стандарт зэрэг захиргааны аргууд эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр өнөөгийн байдлаар хүрээд байгаа ололтод хүрэхэд гол үүрэг гүйцэтгэсэн. Энэ нь ХАУ-д ойрын хугацаанд төрөөс өгөх удирдамж чухал хэвээр байж болох юм гэдгийг харуулж байна.

¹ ҮНБ-ний нэгжид ногдох эрчим хүчний зарцуулалт.

Ерөнхийдөө хийгдээгүй үлдсэн зүйл их байна. Одоо хэрэгжиж байгаа төлөвлөгөө, хөтөлбөрүүд хангалттай өргөн хүрээг хамарч байгаа тул хэрэгжилтийн чанарыг сайжруулахад цаашид хийх ажил, авах арга хэмжээг төвлөрүүлэх шаардлагатай. Энэ нь гаднаас үзүүлэх дэмжлэг туслалцаанд шинэ үүрэг хариуцлагийг бий болгож байна. Өнөөдрийг хүртэл ХАУ-д хэрэгжүүлж ирсэн АХБ-ны зээлийн болон зээлийн бус төслүүд эрчим хүчний хэмнэлт, бохирдлыг онцгой ихээр бууруулсан төдийгүй илүү найдвартай, тогтвортой эрчим хүчний системийг ханган нийлүүлэх ХАУ-ын хүчин чадлыг бэхжүүлж өглөө. АХБ 2007 оноос хойш Үндэсний хөгжил, Шинэтгэлийн Хороо (ҮХШХ), тус байгууллагын Нөөцийн хэмнэлт, байгаль орчныг хамгаалах хэлтэстэй эрчим хүчний хэмнэлтийн үр нөлөө бүхий үнэлгээний системийг (ЭХҮС) аж үйлдвэрийн газрууд болон төсвийн байгууллагуудад бий болгоход удирдамж болох аргуудыг судлахад хамтран ажиллав.

ЭХҮС-д тухайн байгууллага эрчим хүчний үр ашгийн гүйцэтгэлийг үнэлэх, тодорхой чиглэлээр ахиц, дэвшил гаргах зорилтыг дэвшүүлэх, цаашид сайжруулалтыг хийх үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг хийхэд ашиглах багц журмууд ордог.

ЭХҮС-ийг үр дүнтэй хэрэглэж чадвал эрчим хүчний хэрэглэгчид урт хугацаанд эрчим хүчний байнгын жигд хэмнэлт хийж болно. Энэ нийтлэлд АХБ, ҮХШХ-ны хамтран хэрэгжүүлсэн (ТА4948-ХАУ: ХАУ-д Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх) ЭХҮС төслийн судлагааны үр дүн, гол дүгнэлтүүд болон зөвлөмж орсон бөгөөд үр нөлөө бүхий ЭХҮС-ийг бий болгох үндсэн зарчмуудыг цементийн үйлдвэрлэл болон төсвийн байгууллагын жишээн дээр танилцуулжээ.



Сонхуа голын тухай баримтат кино

www.youtube.com/watch?v=VO-CGYu2z-l

Энэхүү баримтат киног усны нөөцийн менежментийг сайжруулах, бохирдлын хяналтыг амжилтад хүргэх аргууд, асуудлын талаар голын ай савын оролцогч талууд, усны нөөцийн мэргэжилтнүүд, хандивлагчид, хувийн хэвшлийн салбар, олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхийг зорьж бүтээжээ. Кинонд усны нөөцийн удирдлагыг сайжруулах, бохирдсон Сонхуа голыг сэргээхэд цогц, уялдаа сайтай, ай савыг бүхэлд нь хамарсан арга шаардлагатай байгааг харуулжээ. Мөн тогтвортой хөгжлийг дэмжихэд эдийн засгийн хөгжил болон байгаль орчны хамгааллын тэнцвэрийг хангах чухал гэдгийг онцлон харуулжээ.

Шведийн Стокгольм хотод 2011 оны 8 сард Дэлхийн усны долоо хоног, 2011 оны 9 дүгээр сард Брисбейнд болсон Голуудын олон улсын симпозиум зэрэг олон улсын арга хэмжээний үеэр уг киног үзүүлжээ.

Сонхуа голын ай сав бол Хятад Ард улсын (ХАУ) гурав дахь том ай сав. Энэ голын ай сав нутагт Хятадын зүүн хойд бүс тэр чигээрээ багтдаг. ХАУ-ын хамгийн их бохирдсон дөрвөн голын нэг болсон Сонгхуа гол саяханыг хүртэл төв суурин газруудын хаягдал ус, цэвэрлэгээ хийлгүйгээр цутгах үйлдвэрийн хаягдал, хөдөө аж ахуйгаас гарсан хаягдлын нэвчилтээр бохирдож, үүний дээр 1950–иад оны хоцрогдсон масс үйлдвэрлэл орчны байдлыг муутгахад нөлөөлж байв.

Азийн Хөгжлийн банк 2001 оноос эхлэн ХАУ–ын зүүн хойд хэсэгт туслалцаа үзүүлж эхэлсэн. Сонгхуа голын бохирдлын эх үүсвэр, төлөв болон цар хүрээг төдийлөн сайн ойлгоогүй байсаны дээр Харбин хотын усан хангамжийн төслийг боловсруулах явцад АХБ–ны оролцоотойгоор бохирдлын ужиг болон хурцадмал хүндэрлүүд аль аль нь байгааг нэн түрүүнд олж харсан байна. Голын усны чанар ноцтой байдалд хүрч үүнийг тогтоох шаардлагатай байж болохыг Засгийн газар ухаарсанаар Сонгхуа голын ай савын усны чанар, бохирдлын хяналтын урт хугацааны, цогц судлагаа хийхийг дэмжсэн.

Энэ судалгаагаар техник мэдлэг хуримтлуулах, ай савын удирдлагын институтчлэлийн бүтэц, тогтолцооны байдлыг тодорхойлон тогтоох, сайжруулах болон урт хугацааны, ай савын хэмжээний хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг тодорхойлоход Засгийн газарт дэмжлэг үзүүлэх хэрэгцээг тусган, хийсэн.

Байгаль орчны тулгамдсан асуудлыг судлахын зэрэгцээ АХБ судалгааны дүнд тулгуурлан бохирдлыг хянахад туслалцаа үзүүлэх ажлыг хийсээр байв. 2005 онд уг голын ай савд бензин тос алдаж бохирдуулсан нь олон улсын анхаарлын төвд орж, уг голыг бохирдлоос цэвэрлэхийн тулд хамтарсан хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр ай савыг бүхэлд нь хамарсан техникийн болон институтчлэлийн шинжилгээ хийх шаардлагатай байгааг тодорхой харуулсан. АХБ–ны дэмжлэгтэй хийсэн судалгаанд орсон бохирдлын хяналтын урт хугацааны эрэмблэл болон хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь усны бохирдлыг бууруулах, усны нөөцийг хамгаалах, хаягдлыг дахин ашиглах, нэвчилтээр тархдаг хөдөө аж ахуйн бохирдуулагчийн хяналт болон хатуу хог хаягдлын үр дүнтэй удирдлагаар дамжуулан усны хомсдлыг шийдвэрлэхэд тустай зүйл болсон. Харбин хотын усан хангамжид өөр эх үүсвэр ашиглах тухай эхэн үед гаргасан шийдвэр 2005 онд Сонгхуа голд химийн бодис алдагдсан үед арга хэмжээ авахад тустай зүйл болсон.

АХБ Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаатай түншлэн, нийт ай савын усны бохирдлын менежментийн чиглэлээр урт хугацааны ажил эхлээд тууштай ажиллаж байгаа нь амжилтын гол хүчин зүйл болоод зогсохгүй дэмжлэг үзүүлж буй салбар бүхэн ай савын хөгжилд дэмжлэг болж, таатай нөхцлийг бүрдүүлэхийн сацуу энэ ажлыг өөрчлөлт авчиргагч гэж хүлээн авч байна. 2011 онд ХАУ болон Оросын Холбооны Улс Сонхуа, голын цэвэрлэгээг одоогийн хийгдсэнээс цааш нь хамтран хийх талаар тохиролцсон билээ. Сонхуа гол дээр авч хэрэглэсэн хөгжлийн арга туршлагыг Ази дахь бохирдсон бусад голуудад үлгэр болгон авч хэрэглэхийг санал болгож байна. Үүнтэй ижил төстэй оролдлогыг цогцоор авч үзэж, техникийн судалгаа болон хангалттай дэмжлэг үзүүлнэ.



Хятад ард улсын үр тарианы ургацын гарцад уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлж буй нөлөөлөл—Бүс нутаг, ургацын төлөв байдал (АХБ-ны эдийн засгийн асуудлаархи ажлын баримт бичгийн цуврал №. 243)

www.adb.org/publications/impacts-climate-change-peoples-republic-chinas-grain-output-regional-and-crop-perspective

Энэ баримт бичигт хөдөө нутгийн өрхийн судлагааны мэдээллийг ашиглан Хятад Ард улс (ХАУ)-ын үр тарианы ургацын гарцад уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлж буй нөлөөллийг шинжилжээ. Энэ нөлөөлөл бүс нутаг бүрт ялгаатай байгааг тарианы өөр өөр төрлүүдээр ургацын хэлбэлзлийг бүс бүсээр хийсэн тооцоог танилцуулжээ. ХАУ-ын ургацад уур амьсгалын үзүүлж буй сөрөг нөлөөлөл ерөнхийдөө бохирдлын өөр өөр нөхцөлд 2030 онд -0.31% -ээс -2.69% хүртэл, 2050 онд -1.93% -ээс -3.07% хүртэл байна гэдгийг судалгааны дүн харуулж байна.

Гэхдээ үр тарианы өөр өөр төрлүүд болон бүс бүрт энэ нөлөөлөл ихээхэн өөр өөр гарсан байна. Судалгааны дүнгээр, үр тарианы төрлөөр авч үзвэл, жишээ нь будааны ургац 2030 онд 15.6–24.26 хувиар, 2050 онд 25.9–45.09 хувиар буурахаар байна. Харин эрдэнэшиш, шошийн ургацад уур амьсгал таатай нөлөөлж, 2030 онд эрдэнэшишийн ургац 18.59–24.27 хувиар, 2050 онд 32.77–49.58 хувиар, шошийнх 2030 онд 0.48–5.53 хувиар, 2050 онд 3.96–6.48 хувиар нэмэгдэхээр байна.

Буудайн ургацад үзүүлэх нөлөө харьцангуй бага байна. Бүсээр нь авч үзвэл, ХАУ-н хойд болон төвийн бүсэд уур амьсгалын өөрчлөлт эерэг нөлөөтэй болохыг загварчлалын дүн харуулж байна. Тухайлбал, ХАУ-ын хойд нутагт үзүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр 2030 онд тус улсын үр тарианы ургац 2.85% – 4.80% , 2050 онд 5.30% – 8.49% хувиар нэмэгдэж байгаа бол ХАУ-ын төвийн бүсэд 2030 онд 3.53% – 4.97% , 2050 онд 8.91% – 13.43% хувиар нэмэгдэхээр байна.


Үр тарианы ургацад тус улсын өмнөд болон баруун хойд бүсийн уурын амьсгалын өөрчлөлтийн эерэг нөлөө нь бага байна. Нөгөө талаас бусад бүс нутагт үр тарианы ургацад уур амьсгалын өөрчлөлт сөргөөр нөлөөлж, 2030 онд ХАУ-ын дорнод нутагт 4.10% – 8.58% , баруун өмнөд нутагт 2.29% – 4.05% , зүүн хойд хэсэгт 2.58% – 2.66% буурахаар байна.



Хятад Ард Улс дахь уурын амьсгалын өөрчлөлт ба Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүс хоорондын арилжааны урсгал (АХБ-ны эдийн засгийн асуудлаархи ажлын баримт бичгийн цуврал №. 244)

www.adb.org/publications/climate-change-and-agricultural-interregional-trade-flows-peoples-republic-china

Уур амьсгалын өөрчлөлт Хятад Ард улсын (ХАУ) хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ихээхэн нөлөө үзүүлж буй бөгөөд энэ нөлөө бүс нутаг болон үр тарианы төрлийн хувьд өөр өөр байгаа юм. Бүс нутаг хоорондын нилээдгүй ялгаа нь бүс хоорондын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний арилжааны загварт өөрчлөлт оруулна. Энэ баримт бичигт өөр өөр бүс, салбарын ерөнхий тэнцвэрийн тооцооллын загварыг ашиглан уур амьсгалын өөрчлөлт энэ загварт үзүүлж байгаа нөлөөг шинжилжээ. ХАУ-ын баруун хойд, өмнөд, төв болон зүүн хойд нутгаас гадагш хандах урсгал 2030, 2050 онд нэмэгдэнэ гэдгийг судалгааны дүн харуулжээ. Харин Дорно, Өрнө болон баруун өмнөд хэсгээс гадагш чиглэсэн урсгал хумигдах ажээ. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааны урсгалд гарах энэ өөрчлөлтийг тусган үр тариа хадгалах, зөөвөрлөх болон тээвэрлэх баазын байршлыг өөрчлөх шаардлага гарна.



Хөгжил дэвшлийн төлөөх түншлэл: Хятад оронд үр нөлөөгөө өгсөн тусалцаа

www.adb.org/publications/impact-stories-peoples-republic-china-partnership-prosperity

Энэ эмхэтгэлийг Азийн хөгжлийн банк (АХБ) Хятад Ард улсын (ХАУ) түншлэлийн 25 жилийн ойд зориулан гаргасан байна. 2011 оны 3 дугаар сард Бээжинд болж, Нобелийн шагналт Жозеп Стиглиц гол илтгэгчээр оролцсон “Орлогын дундаж түвшнээс дэвших шилжилт: Боломж ба бэрхшээл” дээд хэмжээний Форум дээр энэ эмхэтгэлийн нээлтийг хийсэн байна.

ХАУ 1978 онд шинэтгэл эхэлсэнээс хойш гайхалтай өсөлт, хөгжилд хүрээд байна. Тогтвортой өсөлт ядуурлыг бууруулахад гол хөдөлгөгч хүч болсон. АХБ үйл ажиллагаагаа ХАУ-д эхэлсэн 1986 оноос эхлэн хөгжлийн төслүүдэд экспертиз, санхүүжилт өгч эхэлсэн болохоор энэ амжилтад хувь нэмрээ оруулсандаа сэтгэл хангалуун байна. Энэ эмхэтгэлд улиран одсон энэ он жилүүдэд АХБ-ны дэмжлэгээр амжилттай хэрэгжүүлсэн хөгжлийн зарим нэг төслийг он цагийн хэлхээгээр харуулж, эдгээр төслийн үр өгөөжийг хүртсэн хүмүүс, газар нутгийн тухай өгүүлжээ. Тэрхүү хүүрнэл танилцуулга АХБ-ны дэмжлэгээр хэр олон чиглэл, төрлийн төслүүдийг хэрэгжүүлсэнийг харуулж, АХБ болон ХАУ-ын түншлэлийн 25 жилийн олон чухал хэмжүүр, далайцыг илтгэн харуулж байна.

АХБ үйл ажиллагаагаа ХАУ-ын хөгжлийн өөрчлөгдөж буй хэрэгцээг тусган өөрчлөгдөж ирсэн бөгөөд тус улс үзэгдээгүй их шилжилт, өөрчлөлтийг туулахын хэрээр АХБ болон ХАУ-ын түншлэл өргөжин тэлж, гүнзгийрэн зузаарсан билээ. ХАУ одоо АХБ-ны хамгийн том харилцагчийн нэг болоод байна. Сүүлийн жилүүдэд АХБ-наас санхүүжилтийн зэрэгцээ мэдлэг, зөвлөгөө өгөх дэмжлэг болон чадавхижуулах зэргээр “зөөлөн” дэд бүтцэд дэмжлэг үзүүлсэнээр сайн туршлага, бодлогын зөвлөгөөг өөрийн болгож, дэлгэрүүлэх ХАУ-ын чадавхи ихээхэн нэмэгдэн, бэхжсэн байна. ХАУ-ын хөгжлийн зорилтдоо хүрэхэд нь АХБ урьдын адил дэмжлэг үзүүлсээр байх болно. Ирэх 5 жилийн хугацаанд АХБ болон ХАУ-ын хамтын түншлэлийн стратеги ХАУ-ын 12 дугаар таван ижлийн төлөвлөгөөтэй давхцаж байгаа бөгөөд тэрхүү төлөвлөгөөнд авч үзсэн ач холбогдол, эрэмбэлтэй нийцэж байгаа билээ.



АХБ болон Монгол улсын Түншлэл: Маргаашийн сайн сайхны төлөө

<http://adb.org/publications/adb-mongolia-partnership-building-better-tomorrow>

Энэ эмхэтгэлийг Азийн хөгжлийн банк (АХБ) Монгол улсын түншлэлийн 20 жилийн ойд зориулан гаргажээ. 2011 оны 10 сард Улаанбаатар хотноо болсон “Монгол Улс, Азийн хөгжлийн банкны түншлэл: Монгол улс аз жаргалтай, эрүүл энх, эв эетэй ирээдүйд хүрэх зам” сэдэвт Дээд хэмжээний форум дээр АХБ-ны Ерөнхийлөгч ноён Х.Куроода, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нар эмхэтгэлийн нээлтийг хийжээ.

Монгол Улс, Азийн Хөгжлийн банкны түншлэл тус улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж байсан 1991 оноос эхэлсэн түүхтэй. Монгол улсад үйл ажиллагаагаа эхэлсэн анхны олон улсын санхүүгийн байгууллагын нэг нь АХБ байв. Түүнээс хойш хугацаанд АХБ-ны оролцоотойгоор Монголчуудын амьдралд үлдэн хоногшсон олон өөрчлөлтүүд хийгджээ.

2011 оны байдлаар АХБ Монгол улсын хэрэгцээг даган өргөжиж буй өргөн суурьт портфель бүхий хамгийн том, олон талт түнш болоод байна. Монгол улс орлогын дундаж түвшинд хүрч байгаа болохоор АХБ өөрийнх нь олсон амжилтанд тулгуурлан өсөлтийн бат бөх суурийг бий болгохын төлөө ажиллах зориг эрмэлзэл дүүрэн байна. АХБ шинээр хийх санхүүжилтийг өсгөх, хувийн хэвшлийн оролцоог дэмжсэн орчинг бий болгох, бодлого, зохицуулалт болон чадавхийн дутмаг, сул бэхжүүлэн шийдвэрлэж ажиллах замаар эрчимжүүлэгчийн үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Хэтийн төлвийн энэ төсөөлөлд хүрэхийн тулд АХБ тэргүүлэх чиглэлийг тодорхойлсоны дотор дэд бүтэц, бүс нутгийн хамтын ажиллагаа, Монгол улсын Засгийн газраас тодорхойлсон тэргүүлэх чиглэл, стратегитэй ихэд нийцэж байгаа боловсролын салбар багтаж байна. Эдгээр чиглэлээр ажиллахдаа бүс нутгийн

хамтын ажиллагаа, байгаль орчны тогтвортой байдал болон хүйсийн тэгш байдлыг АХБ үйл ажиллагаандаа голлон анхаарна.



Хятад Ард улс, Азийн хөгжлийн банкны мэдлэг солилцооны хамтарсан хөтөлбөр: Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааг дэмжихүй

Энэ эмхэтгэлд Солонгос улсын Пусан хотод зохион байгуулсан Тусламжийн үр ашгийн талаархи Дээд хэмжээний 4 дэхь Форум дээр Өмнөд-өмнөд хамтын ажиллагааны инновацийн жишээ судлагдахуун болгон танилцуулсан Хятад Ард улсын (ХАУ) болон АХБ-ны мэдлэг солилцооны хөтөлбөрийг (МСХ) Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааны шинэлэг жишээ болгож оруулжээ.

Энэ нийтлэлд ХАУ болон АХБ-ны мэдлэгийн салбарт хамтран ажилласан түүх, зорилтууд болон гол гол үйл явдлуудыг улбаалан өгүүлж, төгсгөлд нь мэдлэгийн чиглэлээр хамтын ажиллагаа болон түншлэлийн чиглэл болон тэргүүлэх чиглэлийг танилцуулжээ.

ХАУ-ын Сангийн Яам болон АХБ Өмнөд-өмнөд хамтын ажиллагааг дэмжих МСХ-ийг 2009 онд бий болгосон. Энэ хөтөлбөр нь Ази, Номхон Далайн хөгжиж буй орнуудад тулгарч буй хөгжлийн гол асуудлууд, сорилтуудын шийдлийн талаарх мэдлэгээ хуваалцах, хөгжлийн үр дүнтэй удирдлага, бодлого боловсруулалтад хувь нэмрээ оруулсан, бүс нутагт хүртээмжтэй хөгжлийг дэмжих гол хэрэгслэл юм. ХАУ болон хөгжиж буй гишүүн орнууд (ХБГО) үр дүн нь нотлогдсон арга туршлагаас харилцан суралцах явдлыг дэмжин, түгээн дэлгэрүүлэх үүднээс чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэх болон МСХ-ийн үйл ажиллагааны концепцийг гаргах, дизайныг хийх болон санхүүжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.

МСХ нь бүс нутгийн янз бүрийн салбарт тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх, мэдлэг туршлагаа хуваалцахын тулд улс орон өөрөө авч явах үр дүнтэй хөтөлбөр болох нь батлагдаад байна. Түүнчлэн энэ хөтөлбөр харилцаа, хэлхээ тогтоохыг дэмжин, бүс нутгийн хэмжээнд бодлого боловсруулах түвшинд ажиллаж буй хүмүүсээс бүрдсэн хамт олныг бий болгож байна. МСХ нь бүсийн хамтын ажиллагаа, тодорхой салбарын сэдвээр бодлогын санал солилцоо харилцан яриаг холбон дэмжих нөөц хөшүүрэг болох боломжтой. Эх үүсвэр, хүчин чармайлтыг нэмэгдүүлсэнээр улс орнуудын хоорондын солилцоог дэмжих тэр нөөц боломжид МХХ хүрч чадна.

Бүс нутгийн хэмжээнд мэдлэгийн чиглэлээр өөр ямар ч байгууллагад байхгүй брокерийн үүрэг гүйцэтгэх боломжийг МСХ нь олгож байгаа тул мэдлэгийг нутагшуулан ашиглаж болох тийм төслүүдийг ХАУ болон АХБ Өмнөд-өмнөд хамтын ажиллагаагаар дэмжихэд тохиромжтой байр сууринд байгаа юм. Энэ үйл явцыг чиглүүлэгч, дэмжигчийн хувьд АХБ МСХ-т тулгуурласан яриа хэлэлцүүлгийг бүх оролцогчдод зориулсан өндөр үр нөлөө бүхий зөвлөмж, үр өгөөж болгон хувиргах хамгийн тохиромжтой байр сууринд байна.



Зүүн хойд Ази дахь уур амьсгалын нөлөөний эдийн засгийн асуудлууд


<http://beta.adb.org/publications/economics-climate-change-northeast-asia?ref=themes/environment/publications>

Энэ нь Хятад Ард улс (ХАУ), Япон, Солонгос Ард улс болон Монгол зэрэг улс орж байгаа Зүүн хойд Ази дахь уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засгийн асуудлууд, өсөлтийг нүүрс хүчлийн хийн хаягдал багатай хэрэгслэл болгох стратеги болгох тухай судалгааны урьдчилсан дүнг танилцуулсан бүтээл юм. Уг тайланг 2011 оны 12 дугаар сарын 6-нд Өмнөд Африкийн Дурбан хотод зохион байгуулагдсан Талуудын 17 дугаар хуралдаанд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын конвенцийн үндсэн чиглэлд зориулан танилцуулсан билээ.

Судалгааны дүнд дараах дүгнэлтүүд оржээ. Үүнд:

- Зүүн хойд Азид сүүлийн 50 жилийн хугацаанд дулаарал болж байгаа нь илт ажиглагдаж байна.
- Эргийндагуух нутагт уур амьсгалын өөрчлөлтөөс хамгаалах зардал тус бүс дэхь салбаруудын дасан зохицлын хамгийн өндөр зардал байхаар байгааг шинжилгээний урьдчилсан дүн харуулж байна. Дэд бүтцийн салбарт, дасан зохицлын зардлын хувь хэмжээгээр Монгол улс хамгийн их байх магадлал байна. ХАУ-д дэд бүтцийн салбарт байгалийн гэнэтийн үзэгдлээс (жнь: үер, хуй салхи) үүдэн гарах “зохицлын хомсдол” их гарч магадгүй, үүнийг одооноос бодолцож ажиллах нь зүйтэй.
- Зүүн хойд Азид сөрөг нөлөөллийг сааруулах нөөц боломж ихтэй-2030 онд тус бүс нутгийн энэ нөөц наад зах нь 7,000 гигатон нүүрсхүчлийн давхар ислийн нөлөөг бууруулах нөөц боломжоор хэмжигдэж байна. Энэ нөөц боломжийн ихэнхи нь хасах зардалтай тусч байгаа нь бохирдлыг бууруулах, сааруулах өгөөжөөс үл хамааран эдийн засгийн үр ашигтай байхыг харуулж байна.
- Зүүн хойд Азид уур амьсгалын нөлөөг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлэх нийт зардлыг бууруулахад бүсийн хамтын ажиллагаа тустай байж болох тул маш их ач холбогдолтой. ХАУ-ын нөлөөг сааруулах боломж нь Япон, Солонгос улсын боломжийг нийлүүсэнээс хоёр дахин доогуур хасах зардалтай тусна. Бохирдлыг бууруулахад бүсийн нүүрс хүчлийн эрэлтийн арилжааны хөтөлбөр нь илүү үр ашигтай байж болохоор байгаа тул энэ нөөц боломж бүсийн хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой юм.
- ХАУ уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах арга хэмжээг яагаад авах ёстой вэ гэдгийн маргашгүй үндэслэл болох шалтгаанууд байгаа бөгөөд үүнд агаарын бохирдол, эрчим хүчний аюулгүй байдлын зардал үр ашиг орж байгаа юм.

- Сөрөг нөлөөллийг сааруулах өөрийн өмнө тавигдаж буй энэ зорилгыг ХАУ хэрэгжүүлж чадахгүй бол дэлхий дахины жилийн температурын дундаж утга бараг 2С–өөс давахаар байна.



Хөдөөгийн дэд бүтцээр дамжуулан Эмэгтэйчүүдийн чадамжийг дээшлүүлэх нь: Тээврийн салбарт жэндэрийн тэгш байдлыг хангахуй

www.adb.org/publications/empowering-women-through-rural-infrastructure

Энэ нийтлэлд Азийн хөгжлийн банкны Хүйсийн тэгш эрх, Хөгжлийн хамтын ажиллагааны сангаас санхүүжүүлсэн Орон нутгийн иргэдэд түшиглэсэн хөдөө орон нутгийн зам засварын төслийн талаар өгүүлжээ. Туршилтын энэ төсөлд баруун Юаньань дахь үндэсний цөөнх эмэгтэйчүүд хамрагдсан юм. Төсөл Хятад ард улсын Юаньань мужийн Дэхон Дай дахь Люхи, Лианхи 2 сум болон Жинпо үндэсний цөөнхийн өөртөө засах багт хэрэгжсэн.

Төслөөр баруун Юаньань муж дахь зам засварын бүлгүүдэд хотын эзэмшлийн болон тосгоны сайжруулсан замын байнгын үйлчилгээг зохион байгуулах, хийхэд туслахаар зорьсон. Туршилтын энэ төсөл нь нэг талаас засвар нэн шаардлагатай байсан хөдөөгийн замыг сайжруулах, нөгөө талаас эмэгтэйчүүд, бусад эмзэг бүлгийнхэн үндэсний цөөнх иргэдэд ажлын байр бий болгох үүднээс эмэгтэйчүүд болон бусад эмзэг бүлгийнхнийг (уугуул цөөнх иргэд гэх зэрэг) хөдөөгийн зам засварын ажилд оролцуулсан байна. Сургалт, шинэ ажил болон орлого олох боломж нь эмэгтэйчүүд, тэр дундаа уугуул цөөнхийн бүлгийнхэний чадамжийг дээшлүүлжээ.

Аливаа тээврийн сүлжээнд замын нөхцөл маш чухал. Замын байнгын засварын ажил зохих ёсоор хийгдэхгүй бол зам эвдэрч, зам ашиглагчийн зардлыг нэмэгдүүлэн, аялалын цагийг уртасгадаг. Замын наад захын үйлчилгээг удаан хугацаагаар хойш тавьбал илүү том талбайг хамарсан зардал ихтэй сэргээн засварлалтын ажлыг хийхэд хүрнэ. Хөрөнгө мөнгө хүрэлцэхгүй эсвэл үүнийг хийх техникийн мэдлэг хангалтгүйн улмаас байнгын засвар үйлчилгээг хойш тавих нь элбэг.

Туршилтын энэ төсөл хөдөөгийн замын нөхцлийг сайжруулах, тээврийн зардлыг бууруулах болон тус мужийн хот, тосгодод хүрэх замын саадыг арилгах нөхцлийг хангахад байнгын засвар үйлчилгээг хийх тохиромжтой систем бий болгож болохыг харуулсан. Мөн хөдөө нутгийн үндэсний цөөнхийн бүлгийн эмэгтэйчүүдэд ажлын байр бий болгож, байнгын орлоготой болох боломжийг нээж, амьжиргаа нь дээшлэх арга хэрэгслийг бий болгожээ.



Хятад улсад өнгөн хөрсөнд ойр газрын гүний гео энергийг ашиглалтыг нэмэгдүүлэх тухай


Энэ нийтлэлд Хятад Ард улс (ХАУ) дахь өнгөн хөрсөнд ойр газрын гүний гео энергийг (ӨХОГГЭ) ашиглах технологийн хөгжил болон нөөцийн хувиарлалтад цогц үнэлгээ өгч, ӨХОГГЭ-ийн хөгжил, түүнийг ирээдүйд өргөн хүрээнд ашиглахад өнөөгийн шатанд тулгарч байгаа саадыг давах туулж болох зарим нэг бизнес загварыг санал болгожээ.

Сүүлийн жилүүдэд ХАУ дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж байгаа эрчим хүчний хэрэглэгчийн нэг болоод байна. ХАУ-ын эдийн засгийн огцом өсөлт эрчим хүчний эрэлт эрчимтэй нэмэгдэхэд хүргэсэн хүчин зүйл болохын зэрэгцээ эргээд тэр өсөлтийн үр дагавар болж байна.

ХАУ-ын эрчим хүчний хольцод чулуужилтын гаралтай түлш, ялангуяа цахилгаан, дулааны 80-аас илүү хувийг үйлдвэрлэхэд ашиглаж буй нүүрс хүчлийн хийн хаягдал их гаргадаг нүүрс давамгайлж байна. Өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээ, үүнээс үүдэлтэй байгаль орчны нөлөөнд Засгийн газар анхаарал тавьж, 11 дүгээр 5 жилийн төлөвлөгөөний жилүүдэд (2006–2010) үндэсний нийт бүтээгдэхүүний нэгжид ногдох эрчим хүчний хэрэглээг 20 хувиар бууруулах, сэргээгдэх эрчим хүчний эзлэх хэмжээг нэмэгдүүлэн, эрчим хүчний төрөлжилтийг дэмжих зорилтыг зарласан байна.

1990-ээд оны сүүл үеэс хойш өнгөн хөрснөөс 30–200 метрийн гүнд өргөн тархсан, ӨХОГГЭ-ийн баялагийг ашиглах талаар нилээд судалгаа шинжилгээ, хөгжүүлэлтийн ажил хийгдээд байгаа юм. Энэ нөөц эх үүсвэрийг халаалт, сэрүүцүүлэх үйлчилгээ, эцсийн хэрэглэгчдийг халуун усаар хангахад эдийн засгийн үр дүнг ашигтайгаар ашиглаж болох юм. ӨХОГГЭ-ээр нүүрс, байгалийн хийг орлуулж болох тул хүлэмжийн хийн ялгарал, хүхрийн давхар исэл, азотын хүчил, тоосонцор болон бусад бохирдуулагч зэрэг агаарын бохирдолд нэмэрлэгч хүчин зүйлийг бууруулна. Эхлэл шатандаа явж байгаа, үр дүн нь бүрэн нотлогдоогүй энэ технологийн ашиглалтын зардал өндөр байсан учраас төдийлөн өргөн хүрээнд нэвтрүүлэн хэрэглээгүй ажээ. Өргөжүүлэлтийн өгөөж, технологийн дэвшлээс шалтгаалан ӨХОГГЭ-ийн өртөг буурна гэж үзэж байгаа хэдий ч эхний шатандаа бодлогын чиглэсэн дэмжлэг шаардлагатай. ХАУ-д ӨХОГГЭ-ийг өргөн хүрээнд нэвтрүүлэх, хэрэглэх явдал эхлэл шатандаа байна. Засгийн газар ӨХОГГЭ-ийн хэрэглээг тэргүүлэх чиглэл болгосон бөгөөд олон орон нутгийн захиргаад урамшууллын бодлогыг тодорхойлон гаргаад байна. ӨХОГГЭ-ийн хэд хэдэн туршилтын болон үр дүнг харуулах төсөл Бээжин, Шиньян, Тяньжин болон бусад хотуудад аль хэдийн хэрэгжиж эхлээд байна. Гидрогеологийн нөхцөл, технологийн хоцрогдол, аж үйлдвэрийн бодлого болон бизнесийн нийцтэй загвар зэрэг янз бүрийн хүчин зүйл ӨХОГГЭ-ийг өргөн хүрээгээр ашиглахад саад болж байна.

Салбар болон Сэдэвчилсэн судалгааны цуврал



Аж үйлдвэрийн шилжилтийг дэмжих ерөнхий ухамсар, сэтгэлгээ болон бодлогын байдал ямар байгаад хийсэн судалгаа

Энэ баримт бичигт Хятад Ард улсын (ХАУ) 12 дугаар таван жилийн төлөвлөгөөг бэлтгэхтэй уялдуулан Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны зааврын дагуу аж үйлдвэрийн шилжилтийн талаар хийсэн тусгай судалгааны бодлогын зөвлөмжүүдийг хураангуйлан танилцуулжээ. Энэ судалгаагаар олон улс болон дотоодын аж үйлдвэрийн шилжилтийн шинэ чиг хандлага, өөр өөр бүс нутгийн хөгжлийн давуу талуудыг хослуулсан хөгжлийн үе шатуудын өвөрмөц шинж чанарууд, зах зээлийн механизмуудын үүрэг, олон улсын чансаалаг хэрэглэгчдийн зах зээл болон дотоодын үйлдвэрлэлийн шилжилтийг шинжилжээ.

Судалгаагаар аж үйлдвэрийн шилжилтийг дэмжихэд дараах зарчмыг мөрдөх нь зүйтэй гэсэн дүгнэлт хийжээ. Үүнд:

- Зах зээл болон төрийн удирдлагын аль алинийг баримжаалах, ингэхдээ зах зээл гол үүрэгтэй, төрийн удирдлага туслах үүрэгтэй байна;
- Аж үйлдвэрийн шилжилтийг аж үйлдвэрийн бүтцийн өөрчлөлттэй хослуулах; болон
- Дотоодын аж үйлдвэрийн шилжилтийг олон улсын шилжилттэй хослуулах.

Тодорхой чиглэлээр өгсөн зөвлөмжүүдэд:

- Шинэтгэлийг эрчимжүүлж, аж үйлдвэрийн шилжилтэд саад тээг болж байгаа явуургүй бодлогыг халах.
 - Бодлогыг нийтэд нь баталдаг практикыг шинэчлэх.
- Аж үйлдвэрийн шилжилтийн удирдамж бодлогыг сайжруулж, аж үйлдвэрийн шилжилтийг хэрэгжилтийг хангах үүднээс үндсэн дэд бүтцийг сайжруулах.
 - Зүүн бүсийн аж үйлдвэрүүдийг шинэчлэх үйл явцыг гүнзгийрүүлэх явдлыг урамшуулсан шинэ бодлогыг томъёолох.
 - Төв болон баруун бүсэд үзүүлэх дэмжлэгийг өргөжүүлэх.
 - Аж үйлдвэрийн шилжилтэд үр нөлөөгөө өгөх үндсэн дэд бүтцийг сайжруулах.
- Бүс нутгийн дотоод зохицуулалтын давуу талыг бий болгон, аж үйлдвэрүүдийн хэвтээ холбоог дэмжих.

- Мэдээлэл солилцоо, харилцаа, зохицуулалтын улсын хэмжээний механизмыг бий болгох.
- Шууд хамтын ажиллагааны шинэ загварыг бүс нутаг дотроо эрж хайх, судлах явдлыг урамшуулан дэмжих.
- Аж үйлдвэрийг кластрчилан хөгжүүлэх бүс нутгийн харьцангуй давуу талыг ашиглах.
 - Аж үйлдвэрийн паркуудыг байгуулахыг бэхжүүлэх.
- Аж үйлдвэрийн шилжилтийн интеграцчлал, тогтвортой хөгжлийн төлөөх эрэл хайгуулыг чиглүүлэн залах зэрэг оржээ.



Их дээд сургууль, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны сайн жишээ

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Монгол улсын Ерөнхий сайдын ажлын албанд шаардлагатай бодлогын судалгааг дэмжих үүднээс энэхүү тайланг бэлтгэсэн болно. Энэ тайлан их дээд сургуулиуд мэдлэг мэдээллийг бий болгож, аж үйлдвэр тэрхүү мэдээллийг авч хэрэглэдэг гэсэн агуулгад үндэслэгдэж байна. Үйл ажиллагаагаа аж ахуйн аргаар хөтөлж буй орчин үеийн их дээд сургуулиуд эхлээд судалгааны үндсэн мэдлэгийг бий болгож дараа нь хэрэглээний судалгаагаар түүнийгээ технологи болгон хөгжүүлж, ингэсний дараагаар эдгээрээс сонгон компани дээр нэвтрүүлээд, тэрхүү мэдлэгийг бүтээгдэхүүн, үйлчилгээ байдлаар борлуулдаг. Хэрэгцээнээс хамааран үйлдвэрийнхэн тэр мэдлэгийг нэг бол лицензийн гэрээгээр ашиглаж, эсвэл мэдлэг, технологиос нэгийг нь эсвэл компанийг шууд худалдан авдаг.

Ийм үйлдвэрийг байгуулахын тулд их дээд сургуулиуд аж үйлдвэрийн хөгжлийн өнөөгийн чиг хандлагыг танин мэдэж, шаардлагатай мэдлэгийг тодорхойлон, загвар технологийг сонгоод, олон улсын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох, эсвэл засгийн газар болон засгийн газрын бус сан, вэнчэр, капиталын сангууд, хувьцаагаар хийх хөрөнгө оруулалт зэрэг олон арга замаар санхүүжилт олж, компани байгуулахад хамтран ажиллана. Ингэж гэмээнэ их сургууль-үйлдвэрийн хамтын ажиллагааг бодит биелэл болгох боломжтой болох юм. Их дээд сургууль-үйлдвэрийн хамтын ажиллагаа одоо лиценз эзэмшилээс хувьцааны хөрөнгө оруулалтруу чиглэж байна. Энэ тайланд их дээд сургууль болон үйлдвэрийн хамтын ажиллагааны өнөөгийн байдалд үнэлгээ өгч, олон улсын туршлагыг танилцуулсан бөгөөд үүнд үндэслэн их дээд сургууль үйлдвэрийн хамтын ажиллагааны аргыг нэвтрүүлэх дараах дөрвөн чиглэлийг тодорхойлон санал болгожээ. Үүнд: (i) хуулийн орчинг сайжруулах, (ii) дэд бүтцийг хөгжүүлэх, (iii) санхүүжилтийн механизмыг бий болгох, болон (iv) хүний нөөцийн хөгжүүлэлтийг хийх.



Хятад ард улсын зээлийн хоёр дахь зах зээл

Санхүүгийн зах зээл хөгжсөн олон оронд төрөл бүрийн зээлийн худалдаа хоёр дахь зах зээл дээр хийгддэг. Эдгээр зах зээлийн дотор хамгийн их зохион байгуулалттай нь синдикат зээлийн зах зээл бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд баримт бичиг, арилжааны горимуудын стандартчлалыг хийхэд салбар ихэд анхааран ажилсантай холбоотой юм. Моргейж болон бөөний зээлийн хоёр дахь зах зээл үүнээс зохион байгуулалт тааруу, хувь талууд болон зээлийг цуглуулан бөөгнүүлж буй нэгж байгууллагуудын стандарт, үйл ажиллагааны арга барил, ажиллагаа нь өөр өөр байна.

Энэ тайланд Америкийн нэгдсэн улс болон Европын зах зээлийн туршлага, замналыг нэгтгэн Хятад ард улсын зээлийн зах зээлийн асуудлууд, хувилбаруудын талаархи суурь мэдээлэл болгон танилцуулсан байна.

Тайланд мөн Америкийн нэгдсэн улс болон Европт синдикат зээлийн зах зээлийг бий болгон хөгжүүлсэн байдал болон түүний өсөлтийг тоймлон танилцуулжээ. Тоймд анхдагч болон хоёрдогч зах зээлийн хөгжил, бүтээгдэхүүний төрлүүд, зах зээлийн сегментүүд болон зах зээл дээрх тоглогчдын талаар тайлбарласан байна. Тоймд зээлийн хүү тогтоолт, зээлийн хүүгийн шилжүүлгийн хэлбэрүүдийн талаар тайлбарлан, худалдаа, төлбөр тооцооны талаар нилээд дэлгэрэнгүй өгүүлжээ. Мөн хууль, зохицуулалт, нягтлан бодох бүртгэлийн асуудлыг мөн авч үзсэн байна. Моргейж, бөөний зээлийн хоёр дахь зах зээлийн шинж чанар, худалдааны процессууд, зээлийн борлуулалтын төвлөрсөн, нэгдсэн зах зээлийг хөгжүүлэх боломж, утга учрыг илүү сайн ойлгоход судлагааг цаашид гүнзгийрүүлэн хийх шаардлагатай байж болох юм.



2011–2015 онд Хятад Ард Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэл ба стратегид зориулсан тус улсын санхүүгийн салбарын үнэлгээ

1978–1979 онд эхэлсэн социалист зах зээлд шилжих шилжилтийн үеэс Хятад Ард улс (ХАУ) тус улсын эдийн засгийн өсөлт, тэнцвэртэй хөгжлийг дэмжих үүднээс зах зээлд суурилсан санхүүгийн системийг бий болгохын төлөө шаргуу ажилласан билээ. Өмнөх төвлөрсөн төлөвлөгөөт системээс хоцорч үлдсэн алдаа дутагдлыг арилгах, санхүүгийн байгуулал, зах зээлийн өөрчлөлт шинэчлэлт болон хөгжилд үзэгдэхүйц дэвшил гарчээ

Өнгөрсөн 30 жилийн туршид ХАУ санхүүгийн орчин үеийн системийг дэмжихэд шаардлагатай олон институцийг бий болгож, санхүүгийн зуучлалыг ихээхэн гүнзгийрүүлэхэд хуримтлалыг амжилттай дайчилжээ.

Гэхдээ бүтцийн хувьд нилээд сул хэвээр байна. Сүүлийн 30 жилийн хугацаанд ХАУ дахь санхүүгийн салбарын хөгжилд дэлхийн ихэнх орнуудын адил 2008 оны дэлхийн санхүү эдийн засгийн хямралын нөлөө их байв. Хямралын давалгааны үеэр

Хятад улс илүү тэнцвэртэй, тогтвортой өсөлт, хөгжлийг дэмжихэд санхүүгийн шинэтгэлийг үргэлжлүүлэхэд ач холбогдол өгч, дотооддоо болон олон улсад эдийн засгийн шинэ тэнцвэрийг бий болгохын төлөө чиглэсэн шилжилт хийсэн билээ.

Санхүүгийн салбарын үнэлгээний энэхүү ерөнхий танилцуулгад Хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегийн (ХХТС) баримт бичгийн гол хавсралт болж орсон санхүүгийн салбарын үнэлгээний хураангуйн өмнөтгөл мэдээлэл оржээ. Санхүүгийн салбарын хамгийн сүүлийн үнэлгээ (ССҮ) болон Санхүүгийн салбарын Үндсэн чиглэл (САҮЧ) 2006 онд хийгджээ.

Энэ баримт бичгийн эхэнд 2006 оноос хойш ХАУ-ын санхүүгийн салбарт гарсан гол амжилт, хийгдсэн ажлуудын товч үнэлгээг танилцуулж, цааш нь (i) Засгийн газраас санхүүгийн салбарт хэрэгжүүлж буй өнөөгийн болон цаашид санал болгож буй стратегийн хураангуй танилцуулга; (ii) Азийн хөгжлийн банкнаас (АХБ) болон хөгжлийн чиглэлээр хамтран ажиллаж байгаа бол гол түншүүд, тэр дундаа Дэлхийн банкнаас одоо хэрэгжүүлж буй туслалцааны хөтөлбөрүүд; болон (iii) АХБ-наас санал болгож оролцоог танилцуулжээ.

АХБ-наас дараах гурван чиглэлээр дэмжлэг авах хэрэгцээ, шаардлага байна. Үүнд: (i) хөдөөгийн санхүүжилт, жижиг, дунд аж ахуйд, түүний дотор ногоон хөтөлбөрийн санхүүжилтийн хүртээмж; (ii) хөдөөд тэтгэврийн чиглэлээр хийх ажлууд; болон (iii) санхүүгийн тогтвортой байдал. Эдгээр нь Засгийн газрын санхүүгийн салбарт хэрэгжүүлэх стратегийг дэмжих болон АХБ-ны өмнөх болон одоо үргэлжилж буй оролцоонд суурилан ажиллах чиглэл болж байна.



Хятад ард улсын хувийн хэвшлийн салбарын үнэлгээ

Хятад Ард улсад (ХАУ) нэг хүнд ноогдох орлого болон нийт эдийн засгийн үйл ажиллагаа нэмэгдэхэд хүргэсэн гол хөдөлгүүрийн нэг нь хувийн хэвшлийн үйл ажиллагаа үзэгдээгүй ихээр нэмэгдсэн явдал юм. Одоогоор хувийн хэвшлийн салбарт дотоодын нийт бүтээгдэхүүний гуравны хоёроос илүү хувь ноогдож байна. Аж ахуйн газруудын бараг далан таван хувь нь хувийн салбарынх бөгөөд 11 дүгээр таван жилийн төлөвлөгөөний эхэн үед хувийн байгууллагын тоо 4.3 сая байсан бол 2010 оны эцэс гэхэд 8.4 сая болж нэмэгджээ.²

Гол салбаруудад төр гол үүрэгтэй хэвээр байгаа боловч төрөөс дэд бүтэц, эрчим хүч, байгалийн нөөцийн ашиглалт, боловсрол болон санхүү зэрэг стратегийн гол салбаруудад хувийн хэвшлийн оролцоог тууштай дэмжиж ирсэн.


Дараах гурван шинэтгэл хувийн хэвшлийн хөгжлийг хурдасгасан. Үүнд: (i) 1997 онд Намын 15 дугаар Их хурлын дараа эхэлсэн төрийн өмчийн аж ахуйн газруудын хувьчлал, корпорацийн бүтцэд шилжих

² All-China Federation of Industry and Commerce.

шилжилт; (ii) мөн намын 15 дугаар Их хурал хуралдсан үеэс эхлэн дараагийн арван жилийн эхэн үе хүртэл үргэжлэн хийгдсэн хувийн хэвшлийн салбар төрийн өмчит аж ахуйн нэгжтэй ижил тэгш хуулийн эрхтэй байхад чиглэсэн алхмууд; болон (iii) 2001 онд Дэлхийн худалдааны байгууллагад элссэнээр эдийн засгийн олон салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг чөлөөтэй болгосон.

30 жилийн богино хугацаанд эдийн засгийг нээлттэй болгох, зах зээлийн баримжаатай бизнесийн орчинг бий болгоход ихээхэн амжилт олоод байна. ХАУ-д зах зээлийн эдийн засагруу шилжих замналаа үргэлжлүүлж буй тул тус улсын бизнесийн орчинг улам бүр сайжруулах орон зай байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн төлөөх байгууллагаас (ЭЗХАХТБ) ХАУ-д аж ахуйч сэтгэлгээ, санаачлага, аж ахуйг үр ашигтай хөтлөх орчны жишиг тогтоохоор хийсэн судалгаагаар тус улсад зохицуулалт, захиргааны системийн хэд хэдэн чиглэлээр сайжруулах шаардлагатай байгааг тогтоосон байна.³ Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг Дэлхийн өрсөлдөх чадварын индексийн 2010 оны жагсаалтаар Хятад улс зах зээлийн хэмжээ (2 дугаар байр), макро эдийн засгийг тогтвортой байдлаараа (8 дугаар байр) дээгүүр байранд орсон бол микро түвшингий үзүүлэлтээрээ доогуур байранд, үүний дотор нийт татварын хэмжээ (124 дүгээр байр), бизнес эхлэхэд шаарддаг журам, зааврууд (117 дугаар байр), бизнес эхлүүлэхэд орох хугацаа (99 дүгээр байр) орж байгаа нь цаашид сайжруулах шаардлагатай байгаа чиглэлийн талаар өгч байгаа дохио болж байна.



Хятад ард улсын эрсдлийн үнэлгээ

Энэ нь Азийн хөгжлийн банкны (АХБ) санхүүжилтээр Хятад Ард улсад (ХАУ) хэрэгжүүлсэн худалдан авалт, санхүүгийн удирдлага болон авилгалтай тэмцэх төслийн судалгаа юм. 2011–2015 онд АХБ–ны ХАУ–тай хамтран хэрэгжүүлэх *Түншлэлийн шинэ стратегийн* оршил болгож энэ Судалгааг бэлтгэсэн. Судалгаанд *АХБ–ны Засаглал болон авилгалтай хийх тэмцлийн үйл ажиллагааны хоёр дахь хөтөлбөр* (ЗАТҮАХ II) удирдамжид заасан арга барилыг мөрдлөг болгов.


Судалгаанд хөдөө аж ахуй хөдөөгийн салбарын хоёр, эрчим хүчний салбарын хоёр, нийт дөрвөн жишээ орсон. Судалгаанд эрчим хүч, хөдөө аж ахуй, хөдөөгийн салбарын нэмүү өртгийн сүлжээний шинжилгээ оржээ. Зохих баримт бичгүүд түүний дотор ХАУ–ын эрчим хүч, хөдөө аж ахуйн салбарын санхүүгийн болон авилгалд өртөх эрсдлийн талаархи тайлангууд, хөгжлийн чиглэлээр ажилладаг АХБ–ны түншүүд, түүний дотор олон талт болон хоёр талын хандивлагчид, төрийн бус байгууллагуудаас гаргасан санхүүгийн удирлагын эрсдлийн тухай баримт бичгүүдийг

³ OECD Economic Surveys: [People's Republic of] China, 2010.

олохын тулд онолын бүтээлүүдийг үзэж танилцах, вэб хайлтууд хийх зэрэг аргыг ашиглав.

Судалгаанд ХАУ-ын үндэсний хэмжээний төрийн байгууллага болон өөр өөр агентлагуудын ажилтнууд, төслийн ажилтнууд, хөгжлийн чиглэлээр ажиллаж байгаа түншүүд, компаниуд, төрийн бус байгууллагууд болон бусад оролцогч талуудын төлөөлөлтэй уулзаж авсан ярилцлага орж байна.

Энэхүү судалгааны нэг чухал онцлог нь Парисын Тунхаглалын дагуу тухайн улс орны санхүүгийн удирдлага болон худалдан авалтын системийг амьдралд аль болох ойр байдлаар өөрийн болгон хэрэглэх талаар АХБ-ны хүлээсэн үүргээ биелүүлсэн явдал юм. Тиймээс хэдийгээр зарим нэг дутагдал, сул тал хэвээр байгаа боловч, худалдан авалтын систем, арга практик, санхүүгийн эрсдлийн удирдлага, авилгалтай тэмцэх бодлого, арга ажиллагаа ХАУ-д аль хэдийн хэвшин тогтож байгаа тул зөвлөмж болгосон шинэ чиглэл, стратегитай ижил төстэй санаачлагыг АХБ гаргах цаг иржээ. Үнэлгээний хэсэгт цаашдын чиглэлийн тухай хэд хэдэн зөвлөмжийг оруулсан байна.



Хятад ард улс усны бохирдлын хяналтад зах зээлийн арга хэрэгслийг ашиглаж буй нь

<http://developmentasia.org/documents/reports/instruments-water-pollution-control-prc/default.asp>

Энэ нийтлэлд Хятад Ард улс (ХАУ) дахь усны бохирдол, усны бохирдлын удирдлагын стратегийн өнөөгийн байдлыг авч үзэн бодлогын зах зээлийн арга хэрэгслийг нэвтрүүлэх замаар үүнийг хэрхэн сайжруулах талаар тодорхой зөвлөмжүүдийг өгчээ.

Усны чанарыг харгалзсан усны худалдаа, арилжаа, хураамж, татвар, төр, хувийн хэвшлийн түншлэл зэрэг зах зээлийн арга хэрэгслийг олон улс, ХАУ-д туршаад байна. Тус улсад болон олон улсад энэ арга хэрэгслийг авч хэрэглэсэн туршлага, түүнээс авсан сургамжийг ХАУ-д улам эрчимтэй тавьж байгаа усны бохирдлын хяналтын системийн агуулгын хүрээнд авч үзэж, шинжилсэн байна.

Хуримтлуулсан туршлага, ХАУ-д өгч байгаа бодлогын зөвлөмжүүдийг хөгжиж буй бусад орнуудад энэ чиглэлээр ажиллаж байгаа мэргэжлийн хүмүүст мөн авч хэрэглэхэд тохиромжтой байж болох юм.



Хятад ард улсын хот байгуулалтын тогтвортой хөгжил: Эко хотын хөгжил нь цааш хөтлөх шинэ, тогтвортой арга зам уу?

www.adb.org/publications/eco-city-development-new-and-sustainable-way-forward?ref=themes/environment/publications

Хятад Ард улсад (ХАУ) явагдаж буй хотжилт тус улсын хөгжил, дэвшлийн тусгал болж байна. Гэхдээ эрчимтэй, өргөн хүрээтэй явагдаж буй хотжилтыг дагаад тулгамдсан асуудлууд урган гарч байна. ХАУ-ын хотжилтын түвшин оргил үедээ хүрээд байгаа энэ үед нүүрс хүчлийн хийн хаягдлыг бууруулах концепцид суурилсан эко хотын хөгжил өргөн хүрээнд тавигдаж байна. Хот байгуулалтын олон янзын шинэ загварт “Эко хот” нэр томъёо анхаарал татсан зүйл болж, ХАУ-д эко хотын өөр өөр хувилбар, түүний дотор нүүрс хүчлийн хийн хаягдал багатай болон амьдрах орчныг бүрдүүлсэн хотыг бий болоход хувь нэмрээ оруулж байна.

Энэ баримт бичигт Хятад-Сингапур-Тяньжин Эко хот (ХСТЭХ) төслийн жишээг танилцуулж байна. ХСТЭХ төслийг Сингапурын Засгийн газар болон Тяньжин хотын захиргаа хамтын ажиллагааны төсөл бөгөөд Тяньжин хотын захиргаанд Хятадын Засгийн газраас дэмжлэг үзүүлж байгаа юм. Төслийг Хятад-Сингапур-Тяньжин Эко хотын хөрөнгө оруулалт, хөгжлийн компани нэртэй хамтарсан корпораци удирдаж байна. Мастер төлөвлөгөөг ХАУ болон Сингапурын хот төлөвлөлтийнхөн хамтран боловсруулжээ. ХСТЭХ төслийг 2013 онд эхэлж, 2020 гэхэд хэрэгжүүлж дуусгах зорилт тавьжээ. Төсөл хэрэгжиж дуусах үед 350,000 хүн орон байраар хангагдана.

ХСТЭХ төслийн дэвсгэр нутаг Тяньжин хотоос 40 километр (км), Бээжин хотоос 150 км зайтай 34.2 хавтгай дөрвөлжин километр (км²) талбайг хамарч байна. Тяньжин хот 11.8 сая хүн амтай ХАУ-ын гурав дахь том хот. Хотын газар нутгийн өмнөд хошуу нь Тяньжин Биньхайн шинэ дүүргийн (ТБШД) дагуу сунаж түрсэн, хойд хошуу нь Тяньжиний Эдийн засаг, технологийн хөгжлийн бүстэй (ТЭЗХБ) ойр, нутгийн ихээхэн хэсэг нь давсархаг, үржил шим муутай хөрстэй. 1984 онд байгуулагдсан ТЭЗХБ-г 2006 онд өргөжүүлэн хөгжүүлж, ТБШД-ийг эдийн засгийн тусгай бүс болгон өргөтгөхөөр сонгосон юм.

ХАУ-д эко хот байгуулалтын хөгжил дөнгөж эхэн шатандаа байгаа билээ. Энэ жишээнээс эко хотын хөгжлийг хөтлөх зохистой бодлого, удирдлагын үндсэн чиглэл технологи, санхүүжилтийн хүчин зүйлээс дутуугүй ач холбогдолтой болох нь харагдаж байна.

Одоогийн байдлаар ХАУ дахь эко хотын төслүүд одоогийн хотууд буюу аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ойролцоох бүсэд байршилтай боловч тэднээс саланги шинэ бүтээн байгуулалт байдалтай байна. Энэ шинэ хотуудыг эргэн тойрных нь бүсүүдтэй интеграцчлах хэрэгтэй. Эко хотын элементүүдийн харгалзах зүйлийг одоогийн хотуудад нэвтрүүлэн боловсронгуй болгох замаар хэрхэн нэвтрүүлэх вэ гэдгийг мөн бодолцох хэрэгтэй байна. Түүнчлэн газар зүйн болон үйл ажиллагааны хувьд цомхон эко хотын төслүүд аж үйлдвэр, хотжилтын томоохон бүсүүдэд

байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг бий болгоход хувь нэмрээ хэрхэн оруулах вэ гэдгийг судлах мөн чухал юм. Эко хотуудын мониторингийн үзүүлэлтүүд болон жишиг түвшинг өөр өөр эко хотуудын үр дүнтэй байдал болон өөр өөр арга барилуудыг үнэлэн, харьцуулж болохуйцаар жигдлэн нийцүүлэх хэрэгтэй байж болно. ХАУ дахь эко хотын хөгжил нь хөгжиж буй олон оронд тулгарч байгаа эрчимтэй хотжилтын асуудлыг шийдэх цоо шинэ арга юм.

ХАУ-д хэрэгжиж буй туршилтын төслүүдээс олон сайн туршлагауд бий болно гэж үзэж байгаа юм.

Бусад улс орнуудад хэрэгжээд байгаа эко хотын загваруудын хувьд мөн л орчин нөхцөл нь ялгаатай бусад орны бусад хотуудад нэвтрүүлэн, хуваалцаж болох туршлага гэж үзэж байна. Эдгээр зарчим, арга барилууд хотжилтыг зөв залж байгаа нь тодорхой бөгөөд энэ туршлагыг авч хэрэглэвэл эко хотын загвар нь илүү тогтвортой амьдрахад таатай хотуудыг барихад тустай зүйл болно.




Лаг хаягдлын талаар Хятад ард улсаас баримталж буй стратеги: Тогтвортой шийдлийг дэмжихүй

www.iwapublishing.com/template.cfm?name=w21_dec11_feats
(Эдгээр бүтээлийг ангил хэл дээр захиалан авч болно.)

www.iwapublishing.com/pdf/Water21Chinese_Issue5_Dec2011.pdf?bcsi_scan_97e98328e2b67804=1 (Chinese version)

“Ус 21” сэтгүүлийн 2011 оны 12 дугаар сарын дугаарт орсон энэ өгүүлэлд Хятад Ард улсын (ХАУ) хаягдал ус цэвэрлэх салбарт тулгараад байгаа лаг хаягдлын менежментийн талаар авч үзсэн байна. Сүүлийн 15 жилийн турш ХАУ хотоос гарсан хаягдал усыг цэвэрлэх хамгийн орчин үеийн үйлдвэрийг (ХУЦҮ) барьж байгуулах, ажиллуулах чиглэлээр эрчимтэй бөгөөд тогтвортой дэвшил хийсэн. Гэхдээ энэ амжилтыг дагаад ХУЦҮ-ээс гарч байгаа лаг хаягдлын хэмжээ өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж үүнийг хоёрдогч бохирдол үүсгэхгүйгээр хэрхэн удирдах вэ гэдэг тулгамдсан шинэ асуудал гарч ирсэн.

Лаг хаягдал нь ерөнхийдөө тэжээллэг бодисоор баялаг (азот, фосфор), эрчим хүчийг нөхөн үйлдвэрлэх органик агууламж өндөртэй нөөц боловч удирдлагыг зохих ёсоор хийхгүй бол хүлэмжийн хийг хяналтаас давсан хэмжээгээр ялгаруулан, хөрс болон усны бохирдол, эвгүй үнэр бий болгож болно. Энэ өгүүлэлд лаг хаягдлын удирдлагын олон улсын сайн туршлагаудыг авч үзэн, ХАУ өнөөгийн байдлыг энэхүү сайн туршлагын өнцгөөс шинжлэн үзэж, лаг хаягдлын удирдлыг Хятад ард улс боловсронгуй болгох арга замын талаар санаа дэвшүүлсэн байна.



Замын байнгын засварын ажлыг орон нутгийн иргэдэд түшиглэн хийж эмэгтэйчүүдийг оролцуулах— Замын засварын бүлгүүдэд зориулсан гарын авлага

www.adb.org/publications/community-based-routine-maintenance-roads-womens-groups-manual-maintenance-groups?ref=themes/gender/publications

Энэ гарын авлагыг Хятад ард улсын Юаньань мужийн зам засварын бүлгүүдэд хотын эзэмшлийн болон тосгоны сайжруулсан замын байнгын үйлчилгээг зохион байгуулах, хийхэд туслахыг зорьж бичсэн.

Азийн хөгжлийн банкны хүйсийн тэгш эрх, Хөгжлийн хамтын ажиллагааны сангаас санхүүжүүлсэн Орон нутгийн иргэдэд түшиглэсэн хөдөө орон нутгийн замын байнгын засварын туршилтын төслийн үр дүнд энэхүү гарын авлагыг гаргасан.

Туршилтын энэ төсөл нь нэг талаас засвар нэн шаардлагатай байсан хөдөөгийн замыг сайжруулах, нөгөө талаас эмэгтэйчүүд, бусад эмзэг бүлгийнхэн үндэсний цөөнх иргэдэд ажлын байр бий болгох үүднээс эмэгтэйчүүд болон бусад эмзэг бүлгийнхнийг (уугуул цөөнх иргэд гэх зэрэг) хөдөөгийн зам засварын ажилд зам засварын ажилд оролцуулсан байна. Гарын авлагад үйл ажиллагааны түвшний ажиллах хүч зохистой арга, техникийг ажилдаа авч хэрэглэх заавар өгсөн байна. Энэ гарын авлага Юаньань мужийн Дэхон сумд хэрэгжсэн туршилтын төсөлд хамрагдан ажилласан эмэгтэйчүүдийн бүлгийн засварын ажлаас олж хуримтлуулсан туршлагад үндэслэн хөдөөгийн замын байнгын засварыг хийхэд шаардагдах ажлын болон удирдлагын ур чадварыг эмэгтэйчүүдэд заана.



Замын байнгын засварын ажлыг орон нутгийн иргэдэд түшиглэн хийж эмэгтэйчүүдийг оролцуулах— Мэдээллийн төвүүдэд зориулсан танилцуулга


www.adb.org/publications/community-based-routine-maintenance-roads-womens-groups-guide-communications-bureaus

Энэ нь хотын эзэмшлийн болон тосгоны сайжруулсан замын байнгын засварын ажлыг удирдах, хэрэгжүүлэхэд Хятад ард улсын Юаньань мужийн аймаг, сумын мэдээллийн төвүүдэд зориулсан танилцуулга юм.

Азийн хөгжлийн банкны хүйсийн тэгш эрх, Хөгжлийн хамтын ажиллагааны сангаас санхүүжүүлсэн Орон нутгийн иргэдэд түшиглэсэн хөдөө орон нутгийн замын байнгын засварын туршилтын төслийн үр дүнд энэхүү танилцуулга гарсан.

Туршилтын энэ төсөл нь нэг талаас засвар нэн шаардлагатай байсан хөдөөгийн замыг сайжруулах, нөгөө талаас эмэгтэйчүүд, бусад эмзэг бүлгийнхэн үндэсний цөөнх иргэдэд ажлын байр

бий болгох үүднээс эмэгтэйчүүд болон бусад эмзэг бүлгийнхнийг (уугуул цөөнх иргэд гэх зэрэг) хөдөөгийн зам засварын ажилд зам засварын ажилд оролцуулсан байна. Энэ танилцуулгад Юаньянь мужийн Дэхон сумд хэрэгжсэн туршилтын төслийн хүрээнд эмэгтэйчүүдийн бүлгээс хийсэн зам засварын ажлын жишээг ашиглан орон нутгийн иргэдтэй хөдөөгийн замын байнгын засварын ажлыг хэрхэн зохион байгуулах, сургах, гэрээлэх тухай тайлбарлажээ.




Монгол улс: Замын салбарын хөгжил 2016 онд

www.adb.org/publications/mongolia-road-sector-development-2016

Уул уурхайн асар их нөөц баялаг нь томоохон үйлдвэрлэлийн эргэлтэд орж эхлэхтэй уялдаад Монгол улсын эдийн засгийн өсөлт ирэх арван жилд эрчимтэй хөгжих төлөвтэй байна. Эрчимтэй энэ хөгжлөөс үүдэн тус улсын хөгжил дэвшил, ядуурлын төлөв ихэд нааштай байхаар байна.

Энэ тайланд замын салбарын бодлого, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын орчин хэрхэн өөрчлөгдөх, энэхүү шинэ үүрэг ролио биелүүлэхийн тулд тус салбар хамгийн сайн арга замуудын талаар авч үзжээ. Тус улсын замын дэд бүтцийн хэрэгцээг харвал, замын салбар богино хугацааны дотор асар олон хурдны замын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлж, дараа нь тэрхүү хурдны замуудын засвар үйлчилгээг байнга чанарын өндөр түвшинд байлгах шаардлага тавигдана. Монгол улс замын салбарын санхүүжилт, бизнесийн процесс, зохион байгуулалт, болон боловсролын системийг өргөн хүрээгээр боловсронгуй болгохгүйгээр өнөөдрийн ийм цомхон замын салбарын хүчин чадлыг өргөжүүлсэнээр тавигдах шаардлагыг хангах аргагүй. Тиймийн тул энэ тайланд ирэх 5 жилд замын салбарын хүчин чадлыг хөгжүүлэх цогц хөтөлбөр хэрэгжүүлэхийг Монгол улсын засгийн газарт зөвлөмж болгосон.

Тайланд тус салбарын санхүүгийн багтаамж, замын засвар, барилгад мөрддөг арга техникүүд, процессууд, хүний нөөц, боловсролын үүрэг ролийг авч үзсэн байна. Салбарын олон асуудлууд болон хүлээн зөвшөөрөгдсөн шийдлүүдийг өнгөрсөн хугацаанд аваад байгаа хэрнээ салбарын гүйцэтгэлийн сайжруулалт яагаад удаашралтай байгааг ойлгох оролдлого хийсэн байна. Олон улсын туршлагаас санаа авч, тайланд шийдвэр гаргагчид зориулан бодлогын нилээд олон хувилбарыг танилцуулан, 2016 он хүртэл хийх ажлын хөтөлбөрийг санал болгожээ.



Хятад ард улсад хэрэгжиж буй усны хагалбарын эко нөхөн төлбөрийн тухай

www.adb.org/publications/eco-compensation-watershed-services-peoples-republic-china

Хятад Ард улсын (ХАУ) эдийн засгийн одоогийн хөгжилд ирэх 10–15 жилийн хугацаанд нөөцийн хамгийн их дарамт авчрах цорын ганц гацаа нь ус болж болох юм. Хятад улстай адил том улсуудын дунд нэг хүнд ногдох цэвэр усны нөөцөөрөө хамгийн бага, дээр нь усны бохирдол газар авч байгаагаас хүртээмж нь улам буурч байна. 2011 оны 4 сард хэвлэгдэн гарсан ХАУ-ын байгаль орчны макро стратегийн судалгааны тайланд бичсэнээр Хятад улсад долоо хүн тутмын нэгд ноогдох ундны ус, усны бохирдлын хэмжээний үндэсний стандартыг хангахгүй байгаагийн сацуу Хятадын хөдөө нутагт амьдарч буй 300 сая хүнд ундны цэвэр ус хүрэлцэхгүй байна. Дэлхийн Банкны саяханы судалгаагаар ХАУ-ын усны хямрал дотоодын нийт бүтээгдэхүүний 2.3%-ийн зардлыг бүрдүүлж байгаагийн 1.3% нь усны хомсдол, 1.0% нь усны бохирдлын шууд нөлөөнөөс үүдэлтэй байна.


Тулгамдсан эдгээр асуудлын улмаас засгийн газар болон орон нутгийн захиргаад усны нөөцийн нийлүүлэлт болон эрэлтийн аль аль талын менежментийг сайжруулах шинэ санаа, аргыг эрж хайж, хөрөнгө гаргаж байна. “Эко нөхөн төлбөр” гэсэн өргөн агуулга бүхий нэрийн дор сүүлийн арван жилийн турш үндэсний хэмжээний болон муж, орон нутгийн түвшинд байгаль орчны зах зээлийн баримжаатай бодлогын арга хэрэгслийн олон тооны туршилтууд хийгдсэн нь Засгийн газар Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд (ҮХШХ) Эко нөхөн төлбөрийн журам гаргах үүрэг өгөхөд хүргэсэн.

Эко нөхөн төлбөр нь зөвхөн экологийн үйлчилгээний төлбөрийн мөн чанартай төдийгүй мөн мужуудын захиргаадад ноогдох төсвийн санхүүжилтийн хувиарлалтыг сайжруулах, засаг захиргаа болон бүс нутагт бүгдэд нь хамаатай усны хагалбарын экологийн үйлчилгээ зэрэг экологийн үйлчилгээний урсгалыг тодорхой болгох үүднээс мужуудын захиргаадад төсөв хувиарлах асуудлыг мөн хамарч байна. Экологийн асуудлууд дэлхий нийтэд ихээхэн уршиг учруулан, дэлхийн хүнс, түлшний зах зээлд шууд нөлөөлж, түүхий эд, үйлдвэрлэлийн олон улсын зах зээлд нэлэнхүйд нь хохирол учруулж байгаа тул эдгээр шинэлэг арга, хэрэгслийн амжилт нь зөвхөн ХАУ төдийгүй бусад орнуудад ч маш чухал юм.

Энэ баримт бичигт ХАУ-ын Экологийн нөхөн төлбөрийн үндэсний хэмжээний журмын хувьд ямар ахицтай байгааг танилцуулж, үр дүнтэй журам гаргахад шийдвэр гаргагч түвшнийхэнд институцын чиглэлээр тулгарч буй бэхршээлийг хөнджээ. ХАУ-д усны удирдлагыг Засгийн газар, орон нутгийн олон агентлагуудын дунд тараасан байдгаас ус ашиглалтын эрх тодорхой бус байдлаар томъёологдсон, усны үнийг хиймлээр хэт доогуур тогтооход нөлөөлж, энэ нь чухамдаа нөөцийг дур мэдэн, чөлөөтэй ашиглах, зөрчил үүсэх, нөөцийг хүрэлцэх хэмжээгээр хувиаралахгүйд хүргэдэг. Хууль, журмыг сахиулах Засгийн газрын чадамж султай энэ бүх хүндэрлүүд

хамсарсанаар усны хагалбар, усны нөөцийн үр дүнтэй хамгаалал удирдлагад сөргөөр нөлөөлж байна.

Эко нөхөн төлбөрийн журмыг боловсруулахад энэ баримт бичиг дараах зөвлөмжийг өгчээ. Үүнд: (i) эко нөхөн төлбөр нь голын ай савын интеграцчилсан менежментийг хэрэгжүүлэх хэрэгслэл байх боломжийг авч үзэх,(ii) хатуу чанга байдал, уян хатан байдлын тэнцвэрийг хангах, авчрах өөрчлөлт үр нөлөөг гол болгох, (iii) тоглогчдын цар далайцыг харгалзах.



Хятад ард улсын тогтвортой хөгжлийн байгаль орчны асуудал: Ирээдүйн талаарх төсөөлөл ба Азийн хөгжлийн банкны гүйцэтгэх үүрэг

Хятад Ард улс (ХАУ) 9 хувь давсан эдийн засгийн өсөлттэй явж ирсэн гурав дахь арван жилийг ардаа орхиж байна. Түүхэн энэ гайхамшигтай энэ амжилтын үр дүнд ХАУ-ын эдийн засаг дэлхийн хоёрдох том эдийн засаг боллоо. Гэхдээ энэ амжилт байгаль орчинд сөрөг үр дагавар бас авчирсан. Эдийн засгийн өсөлтөөс үүдэлтэй байгаль орчны үр дагаврыг тогтвортой хөгжлийн үүднээс удирдахад шаардлагатай хууль, журам, дүрэм, институтчлэл, хүний нөөцийн хөгжлийн чиглэлээр Засгийн газраас хийсэн ажлууд энэ амжилтаас дутуугүй анхаарал татсан түүх, сургамж болж, ХАУ-ын нутаг дэвсгэр дээр байгаль орчны хувьд тогтвортой хөгжлийн төлөө олон нийтийн сэтгэл зүйг бий болгоход тустай зүйл болохын зэрэгцээ дэлхий дахины байгаль орчны ач холбогдол бүхий асуудлаар тус улсын байр суур нь байнга дээшлэн чухал үүрэг гүйцэтгэх боллоо. Тус улсын байгаль орчны өргөн агуулга бүхий хөтөлбөрийн цаана эдийн засгийн эрчимтэй өсөлт, эдийн засгийн салбарын бүтэц, эдийн засгийн хөгжлийг хөтлөхөд ашиглаж буй эрчим хүчний эх үүсвэр, өсөн нэмэгдэж буй хотжилт гэсэн өргөн хүрээ бүхий дөрвөн хүчин зүйл байгаа билээ. Орчны чанарыг сайжруулах үүднээс саяхан гарсан ХАУ-ын байгаль орчны тухай макростратегийн тайланд эдийн засгийн хөтөлгөч эдгээр дөрвөн хүчин зүйлийн далайц хүчийг өөрчлөх хэрэгцээг тодорхойлон, 2050 он хүртэлх байгаль орчны хувьд тогтвортой хөгжлийн урт хугацааны төсөөллийг оруулсан байна.

Ирээдүйн тухай энэхүү төсөөллийг эргэцүүлсэн энэ баримт бичигт байгаль орчны хувьд тогтвортой хөгжлийн зүг Засгийн газраас хэрэгжүүлэх шаардлагатай байгаа гол чиглэлүүдийг авч үзэн шинжилсэн байна. Өсөлтийн өнөөгийн тогтвортой бус загварын замналыг өөрчлөхийн тулд ирэх 10 жилд байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөрт дараах чиглэлүүдийг оруулахыг зөвлөмж болгожээ. Үүнд: (i) эдийн засаг, төсвийн системд байгаль орчны хүчин зүйлүүдийг тусган өөрчлөх, (ii) байгаль орчны хөрөнгө оруулалтад илүү хөтөлбөр талаас хандах арга барилыг хэрэглэх, хөрөнгө оруулалтын үр ашгийг улам бүр сайжруулах, (iii) хот байгуулалтын чанарт илүү анхаарах, (iv) бохирдлын хяналтад зах зээлийн арга хэрэгслийг ашиглах явдлыг нэмэгдүүлэх,болон (v) хариуцлагыг

тодорхой болгох, хамтын ажиллагааг дэмжих үүднээс байгаль орчныг хамгаалах хуулинд өөрчлөлт оруулах.

Мөн энэхүү баримт бичигт АХБ-наас тус улсын Засгийн газраас ирэх 10 жилд байгаль орчны асуудлаар хэрэгжүүлэх хөтөлбөрт оруулсан хувь нэмрийн талаар өгүүлэн, АХБ-ны цаашдын оролцооны дөрвөн дараах чиглэлийг тодорхойлжээ. Үүнд: (i) байгалийн нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох, экологийн үйлчилгээний хамгаалал; (ii) байгаль орчны бохирдлын удирдлагыг бэхжүүлэх; (iii) уур амьсгалын өөрчлөлтийн үр дагаврын сөрөг нөлөөг сааруулах болон дасан зохицох арга хэмжээг идэвхжүүлэх; болон (iv) мэдлэг солилцоо, чадавхижуулалт болон бодлогын шинэтгэлийг дэмжих.



Монгол улсын тэтгэврийн даатгал

Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос бэлтгэн гаргасан энэ баримт бичигт Монгол улсын тэтгэврийн тогтолцооны өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлагыг шинжлэн үзэж, сайжруулах шаардлагатай асуудалд анхаарсан байна.

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн явцад нийгмийн даатгалын асуудал нийгэм, эдийн засгийн хөгжлийн нэг чухал асуудал хэвээр байв. Иргэдээ ядуурлын нөлөө, байгаль орчин, эдийн засаг болон нийгмийн сөрөг үр дагавраас хамгаалах арга хэрэгслэл нь нийгмийн хамгаалал гэж үздэг тул нийгмийн даатгалын асуудал Монгол улсын анхаарал татсан гол салбарын нэг болоод байна.

Монгол улсын хүн амын дундаж нас харьцангуй залуу, насжилтын асуудал анхаарал татах асуудал болж тавигдаагүй байгаа ч хүмүүс тэтгэврийн даатгалын асуудлын талаар улам бүр санаа тавих болжээ. Төсвөөс бүрэн санхүүжүүлж байсан өмнөх үеийн тэтгэврийн тогтолцоог 1995 онд шинэчлэн, “Нийгмийн даатгалын тухай” хуулийг баталсанаар ажил олгогч болон даатгуулагчаас төлсөн дээд хэмжээгээр тэтгэвэр олгох зарчмыг мөрдөхөөр болсон.

Тэтгэврийн ийм тогтолцоо ажилгүйдлийн түвшин доогуур байгаа тохиолдолд илүү тохиромжтой гэж үздэг. Монгол улсын тэтгэврийн сан олсон орлогоосоо зардлаа нөхөх хэмжээнд ажиллаж чадахгүй, төрөөс татаас авсаар ирсэн.

Тийм учраас энэ баримт бичигт дараах зөвлөмж өгчээ. Үүнд:

- Тэтгэврийн даатгалыг дээд хэмжээгээр төлөх дундаж цалингийн жишиг хэмжээ цалин хөлсний доод хэмжээнд арайхийн хүрч байгаа тул даатгалын удирдах байгууллага дээд хэмжээний төлбөр, тооцооллын мониторингийг хийх нь зүйтэй.
- Даатгуулагчдад тэдний өнөөдрийн төлж байгаа дэд хэмжээ нь ирээдүйд тэтгэмж авах хэмжээг баталгаажуулж байгаа гэсэн ойлголтыг сайтар ойлгуулах сургалт явуулах.

Даатгалд төлж байгаа дээд хэмжээ нь цалин хөлсний зохих түвшинд үндэслэсэн байх үүднээс ажил олгогчид ажиллагсдын цалин хөлсийг үнэн зөв тайлагнах хэрэгтэй.

- Насны тодорхой хязгаарт хүрсэн бүх иргэд тэтгэвэрт гарсан хугацаандаа баталгаатай орлоготой байлгах үүднээс татвараас эх үүсвэр нь бүрдэх бүх нийтийн тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх.
- Тэтгэвэрт гарсан хугацаанд орлогыг баталгаатай байлгах үүднээс даатгалд үндэсний хэмжээнд хамруулан, санхүүгийн чадвар нь ялгаатай иргэдийн хэрэгцээг тусгасан олон шатлалт тогтолцоог нэвтрүүлэх.
- Ажил олгогч болон ажиллагсдын хэн хэн нь тэтгэврийн даатгалыг дээд хэмжээгээр төлөхөд хувь нэмрээ оруулан, өгөөжийг нь хүртэж байх даатгалын тийм бодлогыг боловсруулах.
- Нийгмийн хамгааллын асуудлыг тусган, хянаж байх албан ёсны удирдамж, механизмыг бий болгож, нийгмийн хамгааллын салбарт гарч байгаа өөрчлөлтийн талаар түншүүдэд тогтмол мэдээлж байх.


Сайн туршлагын цувралууд



Техник мэргэжлийн боловсрол, сургалтын сайн туршлага

www.adb.org/publications/good-practice-technical-and-vocational-education-and-training

Азийн хөгжлийн банкны (АХБ) гишүүн хөгжиж буй олон орнуудад (ХБГО) мэргэжилтэй ажилчны дутагдал хурцадсан асуудал болж байна. Энэ нь Техник мэргэжлийн боловсрол, сургалтын (ТМБС) чиглэлээр АХБ-аас үзүүлж буй дэмжлэгийн сайн туршлагын тухай товхимол бөгөөд ХБГО-уудын оролцогч талуудын дунд ТМБС салбар болон түүний чиглэлийн талаар хэлэлцүүлэг хийх зөвлөгөөг өгсөн байна. Товхимолд стратегийн асуудлыг дэвшүүлэн, хөрөнгө оруулалтын дизайн, түүний дотор сургалт болон санхүүжилтийн өөр өөр хэлбэрийн давуу, сул талуудыг авч үзэн, тайлбарлажээ. Энэ салбарт АХБ-ны хийсэн ажлын туршлагаас авсан сургамж, ТМБС-ын шинэ төслүүдэд тэдгээр төслийн сургамжаас авах зүйлийн талаар энд танилцуулсан байна. Энд оруулсан шалгах хуудас нь ТМБС-ын санал болгож буй хөрөнгө оруулалтыг үнэлэхэд хэрэглэж болох практик хэрэгсэл болох юм. Товхимол Хятад хэл дээр 2011 онд гарсан.



Удирдамж: АХБ-ны усны төслүүдэд усны аюулгүй байдлын төлөвлөгөөг оруулах нь

Азийн хөгжлийн банк (АХБ) төслийн багууд төслийн төлөвлөлт, хэрэгжилтийн ажилд усны аюулгүй байдлын төлөвлөгөөг (УАБТ) оруулдаг тул энэхүү товхимолд тэдэнд хэрэгтэй удирдамж болох зүйлийг оруулав. Товхимолд УАБТ-г танилцуулан, хэрэглэгчдийн ашиглаж буй усны чанарыг сайжруулах болон АХБ-ны хөрөнгө оруулалтын урт хугацааны гүйцэтгэлд эдгээр төлөвлөгөө ямар ач холбогдолтой болохыг тайлбарлажээ. Энд орсон удирдамж нь хот, хөдөөгийн усан хангамж, эрүүл ахуйн төслүүдэд голчлон хамааралтай боловч усан хангамжийн эх үүсвэр, системд нөлөөтэй ямар ч төсөлд үүнийг авч хэрэглэж болох юм.

Энэ удирдамжид УАБТ нь төслийн циклийн шат бүрт ямар ач холбогдолтой байх гурван гол асуудлыг тусгасан нь маш хэрэгтэй зүйл болсон. Үүнд:

- төслийн бэлтгэл шатны техникийн туслалцааны (ТБШТУ) явцад ажлын даалгаврын баримт бичгийг бэлтгэхдээ төслийн дизайн болон хэрэгжилтэд УАБТ-г заавал оруулсан байх;
- төслийн хэрэгжилтийн явцад тухайн баримт бичиг нь талууд харилцан тохирсон УАБТ-н хэрэгжилтийг хянах хэрэгслэл; болно
- төслийн хаалтын үед тухайн баримт бичиг нь УАБТ-ний үнэлгээг хийх удирдамж болж өгнө.

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас (ДЭМБ) УАБТ-г таниулан сурталчилж байгаа тул Ундны усны чанарын удирдамжид орсон үндсэн үзүүлэлтүүд болон сайн туршлага энд орсонг дараах ишлэлүүдээс харж болно. Үүнд:

Ундны усны хангамжийн аюулгүй байдлыг гуйвалтгүй хангах хамгийн үр дүнтэй арга хэрэгслэл нь усны эх булгаас нь эхлээд эцсийн хэрэглэгч хүртэлх бүх шат дамжлагыг нэлэнхүйд нь хамарсан эрсдлийн үнэлгээ, эрсдлийн удирдлагын цогц арга юм. [...] ийм аргуудыг УАБТ хэмээн нэрлэдэг.

Өртөг өндөртэй боловч усаар дамжин тархдаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж чадаагүй, усан хангамжийн системийн аюулгүй байдлын ажиглалт хяналтад илүү анхаардаг усны чанарын мониторингид хэт шүтсэн усан хангамжийн системийн мониторингээс татгалзах зориулалтаар УАБТ –г анх нэвтрүүлсэн. Тэгвэл усны чанарын сорил нь зөвхөн УАБТ-ний үр дүнтэй байдлыг баталдаг.

УАБТ нь урсдлийн хяналт, удирдлагын зарчимд суурилсан системийн үнэлгээ, мониторинг, сайжруулалтын тасралтгүй процесс юм. Энэ төлөвлөгөө нь усаар хангадаг ямар ч байгууллага хийж, ашигладаг баримт бичиг бөгөөд үүнд тухайн УАБТ-ний боловсруулалт, хэрэгжилтийг ерөнхийд нь хянах, УАБТ-д тодорхойлон зааж оруулсан тодорхой үйл ажиллагааг хэн хариуцахыг харуулдаг. УАБТ–г дараах чиглэлийг багтаасан системийн нарийвчилсан үнэлгээгээр эхэлнэ. Үүнд:

- (i) Усны эх булаг үүсвэрээс эхлээд цэвэрлэгээ, нөөцлөл хуримтлуулал, дамжуулалт, түгээлт, эцэст нь эцсийн хэрэглэгчид очих хүртэлх усан хангамжийн системийн дэлгэрэнгүй танилцуулга;
- (ii) Нийлүүлж буй усны аюулгүй байдалд нөлөөлж болох аюул эрсдлийн (бодисууд болон осол, гэмтэл) жагсаалт;
- (iii) Аюул болон осолт гэмтэлтэй холбоотой эрсдлийн үнэлгээ;
- (iv) Ноцтой эрсдлийг бууруулах, хорогдуулах хяналт, урьдчилан сэргийлэх ажлын шалгалт, ийм хяналт, үнэлгээ байдаг бол мониторингийн үйл ажиллагааны хуваарь;

- (v) Хяналт, урьдчилан сэргийлэх ажлын үр дүнгийн түвшинг үнэлэн тогтоож нотолгоожуулах процесс;
- (vi) Шаардлага сайжруулалтыг хийх хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;
- (vii) Нотлох баримт, хийгдэж буй буй бүртгэлийн жагсаалт;
- (viii) Систем байнга найдвартай байгааг харуулсан баримт; болон
- (ix) Усны аюулгүй байдлын байнгын төлөвлөлтийн хуваарь.

Техникийн асуудлаархи цуврал тэмдэглэл



Хөгжиж буй эдийн засагтай орнуудад нүүрс хүчлийн хийн хаягдлыг олдворлох, нөөцлөх үйл ажилллагааг санхүүжүүлэх тухай

Нүүрсхүчлийн хийн хаягдлыг олдворлох, нөөцлөх (НХХОН) технологи дэлхийн хэмжээнд нүүрсхүчлийн давхар ислийн (CO₂) хаягдлыг зардлын үр ашигтай байдлаар хорогдуулахад чухал ач холбогдолтой юм. Гэвч цөөн хэдэн орон эрчим хүчний портфольдоо НХХОН талаархи төсөөллөө оруулж, дэмжих бодлогоо гаргаад байна. CO₂-нь үнэ бодитой бус, нүүрсхүчлийн хийн хаягдлын талаар олон улсад ирээдүйд ямар дэг барих нь тодорхой бус байгаа нь эдийн засаг, арилжаа болон санхүүжилтэд цоорхой бий болгож, НХХОН-ийг санхүүжилтэд өндөр эрсдэлд оруулж байна. Эдийн засгийн цоорхойг нөхөх, НХХОН-ийг бодит жишээн дээр харуулах эхний төслүүдийг дэмжин урамшуулах үүднээс олон тэр бумаар яригдах долларыг төсвийн шууд хөрөнгө оруулалтаар хийгээд байна.

Гэхдээ хөгжиж буй эдийн засагтай орнуудад зориулсан тийм механизм байхгүй байна. Олдворлосон CO₂-г ашиглах, нүүрсхүчлийн хаягдлын бүртгэл бичилтээр ирээдүйд орох орлогыг тодорхойлох нөөц бололцоо нь урт хугацааны өсөн нэмэгдэх зардал, эрсдлийг хорогдуулж болох юм. Гэхдээ энэ нь дангаараа хөгжиж буй эдийн засагтай орнуудад НХХОН-ийг бодит жишээн дээр харуулах эдийн засгийн томоохон зөрөө, цоорхойг нөхөхөд хангалттай биш. Хөгжиж буй орнуудад чулуулгын гаралтай түүхий эдийн (ялангуяа нүүрсхүчлийн хийгээр баялаг нүүрс) эрэлт улам бүр нэмэгдэж байгаа энэ үед НХХОН-н чиглэлээр ахиц дэвшил төдийлөн гарахгүй байгаа нь хөгжиж буй эдийн засагтай орнуудад НХХОН-ийн үр дүнг тод харуулах жишээ төслүүдийг ойрын үед яаралтай хэрэгжүүлэх үндэслэл болж байна. НХХОН-д зориулсан сан нь капиталын өсөн нэмэгдэх өндөр зардлыг нөхөхүйц том, хөгжиж буй эдийн засагтай орнуудад эрчим хүчний торгууль байж гэмээнэ НХХОН-ийн жишээ төслийг эхлүүлж, түүнийгээ бусад арга замаас илүү эрт өрсөн шингээх болно.



Хятад улс дахь цахилгаан станцуудын тэнцвэрт бус өгөгдөл бүхий Malmquist-н нийт хүчин зүйлийн бүтээмжийн индекс ташиглалтгүй хаягдлыг оруулах нь

www.tandfonline.com/doi/abs/10.1080/13504851.2011.572843#preview

Энэ нь 2011 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн “Хэрэглээний эдийн засгийн булан”-д гарсан сэтгүүлийн өгүүлэл юм. Өгүүлэлд ашиглалтгүй хаягдлын (ж.нь., хаягдал хий) Malmquist Нийт хүчин зүйлийн бүтээмжийн (НХЗБ) индекс ташиглалтгүй буй нөлөөллийг авч үзжээ. Эмпирик судалгааны ажилд 1996–2002 онд Хятад Ард улсын (ХАУ)-ын нүүрсээр ажилладаг цахилгаан станцуудын тэнцвэрт бус өгөгдөл бүхий мэдээллийн 1,626 бодит тохиолдлын ажиглалтын үр дүнг ашиглав. Malmquist индексийг тооцоход шаардлагатай тэнцвэрт өгөгдөл бүхий мэдээллийн шаардлагыг хангахын тулд нэгэн цоо шинэ зохиомол нэгжийг авч хэрэглэсэн. Өмнө НХЗБ-н өөрчлөлтийн талаар хэвлэгдсэн нэг ч бүтээлд энэ аргыг хэрэглээгүй байна. Тооцоолол судалгааны эцсийн дүн дараах дүр зургийг харуулж байна. Үүнд: (i) ХАУ-ын цахилгаан эрчим хүчний 2020 оныг хүртэлх өсөлт эхэн үедээ эх үүсвэрийн орц нэмэгдсэнээс голлон хамааралтай байсан (ii) ХАУ-ын нүүрсээр ажилладаг цахилгаан станцуудыг байгаль орчны НХЗБ өөрчлөлт нь 2%–3% орчим (наад зах нь SO₂-тэй холбож авч үзэхэд), байсан бөгөөд энэ өөрчлөлт нь судалгаагаар хамруулан авч үзсэн хугацаанд үр ашгийн өөрчлөлт гэхээсээ илүү техникийн өөрчлөлтөөс үүдэлтэй байна.

Өгүүлэлд арга зүйн гурван шинэ саналыг дэвшүүлсэн байна. Нэгдүгээрт, энэ өгүүлэлд ХАУ-ын нүүрсээр ажилдаг цахилгаан станцуудын нийт НХЗБ өөрчлөлтийн хэмжихэд хаягдал хийг хэмжих шинэ Malmquist индексийг тодорхойлон гаргаж ирсэн. Хоёрдугаарт, цэвэр байгаль орчны гүйцэтгэлийн шинэ индексийг тодорхойлсон бөгөөд энэ индексийг ашиглан шийдвэр гаргагч нэгжийн байгаль орчны чиглэлээрхи гүйцэтгэлийг хэмжиж болно. Гуравдугаарт, шинээр нэвтрүүлсэн зохиомол нэгжийг хэрэглэснээр тэнцвэрт бус өгөгдөл бүхий мэдээллийг ашиглан Malmquist НХЗБ-ийг тооцох боломжтой болж НХЗБ байна. Судалгаанд ашигласан энэ шинэ аргачлалыг цаашид мэдээлэл нь байвал хийн хаягдлын илүү олон төрөл, түүний дотор CO₂-г тооцоход ашиглаж болох юм.

Энэ өгүүлэл судалгааны аргачлалд хувь нэмрээ оруулаад зогсохгүй мөн бодлогод үр нөлөөтэй байна. Судалгааны дүнгээс үзвэл нэгдүгээрт 1996–2002 онд байгаль орчны нөлөөг бууруулахад чиглэсэн НХЗБ өөрчлөлт жилд ойролцоогоор 2.2% байжээ. Энэ дүн илүү үр ашигтай цахилгаан үйлдвэрлэлийн салбарыг барьж байгуулахаар Засгийн газраас авсан арга хэмжээг баталж байгаагийн дээр 1980-аад оны эхээр үр ашиг муутай ажиллаж байсан маш олон жижиг үйлдвэрийг том, эрчим хүчний үр ашигтай ажиллагаатай нэгжүүдээр сольсон үйл явцтай таарч байна. Гэхдээ, ХАУ-ын нүүрсээр ажилладаг эрчим хүчний салбар

орцын өсөлтөөс хэт хамааралтай хэвээр байгааг судалгааны дүн харуулж байна. Байгаль орчны НХЗБ жилд 2.0% байгаатай харьцуулахад энэ хугацаанд хүчин чадлын өсөлт жилд 6.8%, цахилгаан үйлдвэрлэлийн өсөлт жилд 10.3% байсан нь үүнийг нотолж байна.⁴ Хоёрдугаарт, 1996–2002 онуудад Байгаль орчны НХЗБ–ийн өсөлтийн гол хүчин зүйл нь удирдлагын үр ашиг гэхээсээ илүү техникийн өөрчлөлт байгаа юм. Бодлогын талаас нь харвал НХЗБ индексийг үр ашигт гарсан өөрчлөлт болон техникийн өөрчлөлт гэж ялган салгаж үзэх нь маш ач холбогдолтой байна. Жишээ нь хариуцлаггүй цалгар удирдлагыг өөрчлөн сайн туршлага хэрэгжүүлэгч удирдлага болгосоноор НХЗБ–ийн эерэг өөрчлөлт гарсан бол өгч буй зааварчилгаа нь эрс өөр байх болно. Өмнөх тааруу удирдлагатай байгаа үед Засгийн газрын хариуцсан байгууллага технологийн шинэчлэлийг дэмжих үүднээс санхүүжилтийн эх үүсвэр нэмж болох байсан бол удирдлага эрс сайжирсан тохиолдолд тохируулагч, зохицуулагч байгууллага хаягдлыг бууруулахад илүү анхаарах юм.

Гуравдугаарт, 1996–2002 онуудад үр ашгийн өсөлт буюу байгаль орчны гүйцэтгэл илт сайжирсан зүйлийг өгүүлэлд олж тогтоогоогүй байна. Энэ нь ХАУ–ын нүүрсээр ажилдаг цахилгаан станцуудын үр ашиг, хаягдал хийн хяналтыг сайжруулах асар их нөөц боломж байгааг харуулж байна.

⁴ Тооцоонд ашигласан боловсруулсан мэдээллийг Хятад Ард улсын Эрчим хүчний салбарын статистикийн эмхэтгэлээс (2004) авав.

Зүүн Азийн Газар 2011 Мэдлэгийн Удирдлагийн Санаачилга

Жил тутам гардаг энэхүү эмхэтгэл нь мэдлэгийн удирдлагын чиглэлээр Азийн хөгжлийн банкны Зүүн Азийн Газраас (ЗАГ) 2011 онд санаачлан хийсэн ажлын үр дүнг тоймлон танилцуулж байна. Мэдлэгийн удирдлага нь Хятад Ард улс (ХАУ) болон Монгол улсад ЗАГ-аас явуулж буй үйл ажиллагааны салшгүй хэсэг юм. Энэ удаагийн эмхэтгэлд 2011 онд үр дүн нь гараад байгаа стратегийн мэдлэгийн чиглэлээр 39 үйл ажиллагааны товхимолыг дээжлэн танилцуулж байгаа бөгөөд эдгээр ажлын тайланг бүрэн эхээр нь үзэж танилцах вэб холбоосуудыг мөн энд оруулав.

Азийн Хөгжлийн Банкны тухай

Азийн Хөгжлийн Банкны зорилт нь Ази Номхон далайн орнуудыг ядуурлаас ангижруулах бөгөөд гол зорилго нь хөгжиж буй гишүүн орнуудын ядуурлыг бууруулах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэгддэг. Бүс нутгийн хувьд амжилт ахицаар баялаг байгаа хэдий ч дэлхийн нийт ядуу иргэдийн гуравны хоёр нь энэхүү бүс нутагт амьдарсаар байна. Үүнд: өдөрт 2 ам доллараас бага орлоготой хүн амын тоо 1.8 тэрбум, өдөрт 1,25 ам.доллараас бага орлоготой иргэдийн тоо 903 сая хүрчээ. АХБ нь бүх нийтийг хамарсан эдийн засгийн өсөлт, байгаль орчны тогтвортой өсөлт болон бүс нутгийн хамтын ажиллагааг хангах замаар ядуурлыг бууруулахын төлөө ажилладаг юм.

Манила хотод төвтэй АХБ нь нийт 67 гишүүн улстай бөгөөд үүний 48 нь тус бүс нутагт оршдог. АХБ нь хөгжиж буй гишүүн орнууддаа бодлогын хэлэлцүүлэг, зээл, хөрөнгө оруулалт, баталгаа гаргах, буцалтгүй тусламж болон техникийн тусалцаа зэргээр дамжуулан дэмжлэг үзүүлдэг.

6 АХБ-ны гудамж, Мандалаяонг Сити
1550 Метро Манила, Филиппин
Утас +63 2 632 4444
Факс +63 2 636 2444
Хэвлэлийн дугаар. ARM125270

Сүрлэг 2012